Импорт, экспортын бодис, бараа, бүтээгдэхүүний нийт 8566 дээж лабораторийн шинжилгээнд хамруулсны төлбөр 574.697.800 төгрөг, улсын хилээр нэвтрүүлэх гэрийн тэжээвэр амьтан, хувийн хэрэгцээний зориулалтаар авч гарах мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн экспортын гэрчилгээ 1037-г олгож 10.370.000 төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн.

Хүнс, эмийн аюулгүй байдлын шаардлага хангаагүй 26 нэрийн 1 тэрбум 14 сая 800 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг гаалийн горимоор устгаж болзошгүй эрсдэлээс сэргийлсэн.

Хүрсэн үр дүн: Гүний хяналтын бүсээр олон улсад шуурхай болон тогтмол мэдээлэх мал, амьтны халдварт өвчин дамжин тархаагүй, импортын мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт 1.7 хувиар дээшилж, 76.5 хувьд хүрч, баримт бичгийн болон чанар аюулгүй байдлын зөрчил 3-4 пункт, тээвэрлэлт, хаяг шошгын зөрчил 5 пунктээр буурсан.

1.1.8 АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР АВСАН

АРГА ХЭМЖЭЭ

“Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд харьяалагдах 154 хороо, Эмээлт, Морин Өлзийт-1, 2, Гүнт, Баруунтуруун, Гачуурт, Хонхор зэрэг авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоод болон маршрутын бус цэгүүд, “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн ажиллагаа, хангамжийн 10 бааз, дундын 17 агуулах, борлуулалтын 390 цэгүүдэд нийт 453 улсын байцаагч, албан хаагчид хяналт тавин ажиллалаа.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар

Тайлант хугацаанд агаарын чанарын хяналтын чиглэлээр дараах төлөвлөгөөт шалгалтуудыг хийсэн.

1.“Агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагчдад хяналт шалгалт хийх тухай” удирдамжаар 100 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 100(100%) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 182 зуух ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, 13 зуухны хаягдал утаанд хийн хэмжилт хийж эрсдэлээр үнэлэхэд 23(23%) их, 45 (45.2%) дунд, 31 (31.8%) бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Шалгалтаар нийт 368 зөрчил илрүүлж илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 129 заалттай 44 албан шаардлага, 36 албан даалгавар хүргүүлж, 42 579.0 мянган төгрөгийн торгууль ногдууллаа.100 квт-аас дээш хүчин чадалтай зуух ашиглагч төрийн өмчийн 62 ААНБ-д мэдэгдэл, 12 сургууль, цэцэрлэгт зөвлөмж хүргүүлэн, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглагч 68 хуулийн этгээдэд Засгийн газрын 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд сэдвээр сургалт зохион байгуулсан.

Хүрсэн үр дүн: Их эрсдэлтэй объект 17% буурсан, дунд эрсдэлтэй объектын тоо ижил түвшинд, бага эрсдэлтэй объект 17.99% болж өссөн.

2.“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, хий цэнэглэх станц, шатахуун түгээх станц, автомашиныг хийгээр цэнэглэх станцуудын үйл ажиллагаанд хийх шалгалтад 8 (100%) хамрагдаж, 3 (37.5%) их, 2 (25%) дунд, 3 (37.5%) бага эрсдэлтэй үнэлэгдлээ.

Шалгалтаар нийт 40 зөрчил илрүүлж 15(37.5%)-ыг арилгуулан, улсын байцаагчийн 16 заалттай 4 албан шаардлага өгч, барилга байгууламжийг байнгын ашиглалтад улсын комисст хүлээлгэж өгөөгүй үйл ажиллагаа явуулж байсан 5 ШТС-уудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, 4.0 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдууллаа. Нийт 221 ШТС, 55 АХЦС-уудын шатахуун болон шингэрүүлсэн шатдаг хий хадгалах савнуудын бүртгэлийг шинэчлэн, улсын бүртгэлд хамрагдаагүй савны тоог гаргаж, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар, Ашигт малтмал, Газрын тосны газарт бүртгэлжүүлсэн.

Хүрсэн үр дүн: Их эрсдэлтэй объект 15%-иар буурч, хууль тогтоомжийн хэрэгжилт 2% пунктээр, албан шаардлага, албан мэдэгдлийн хэрэгжилт 5 пунктээр сайжирсан.

3. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн их багтаамжийн автобусны утааны тортогжилтын хэмжээнд хяналт шалгалт хийхэд 17 (100%) аж ахуйн нэгж, байгууллагаг хамрагдаж, 5 (29.5%) дунд, 12 (70.5%) бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

224 автобус хамрагдсанаас 161 (71.9%) нь стандартын үзүүлэлт, шаардлагыг хангаж, 63 (28.1%) нь утааны тортогжилтын хэмжээ стандартаас хэтэрсэн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 10 аж ахуйн нэгжид 8.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, улсын байцаагчийн 15 заалттай 5 албан шаардлага, 10 албан даалгавар, 2 зөвлөмж хүргүүлсэн.

Хүрсэн үр дүн: Улсын байцаагчийн тавьсан албан шаардлага, албан мэдэгдлээр өгсөн үүрэг далгаврын хэрэгжилт 36% байна. Хяналт шалгалтын талаар 2 сонин, 3 телевиз, 1 сайтад мэдээлэл хийв. 13 аж ахуйн нэгж, байгууллагын 63 автобусанд засвар үйлчилгээ хийлгүүлж, утааны тортогжилтыг дахин хэмжүүлж, стандартад нийцүүлээ.

4. "Шахмал түлшний үйлдвэрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан 12 (100%) аж ахуйн нэгж хамрагдаж, 6 (50%) аж ахуйн нэгж их эрсдэлтэй, 1 (8%) аж ахуйн нэгж дунд эрсдэлтэй үнэлэгдсэн, 5 (42%) аж ахуйн нэгж угаасан нүүрс /мидлинг/-ний нөөцгүй шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй Таван толгой түлш, МСРТ, Усу коал, Хотын түлш, Ширээтийн хурд, Дэрст тохой, Монгол сайжруулсан түлш ХХК-иудын нүүрсэн шахмал, үртсэн шахмал түлшнүүдээс 28 дээж авч лабораториудад шинжлүүлсэн дүнг үндэслэн улсын ахлах байцаагчийн 28 дүгнэлт гаргалаа. Шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй 2 ААНБ-д 7500.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан улсын /ахлах/ байцаагчийн 2 албан шаардлагыг Таван толгой түлш ХХК-д тус тус хүргүүлсэн.

Хүрсэн үр дүн: Шалгалтын талаар 3 телевиз, 2 сонинд мэдээлж, МХЕГ, НМХГ-ын вэб сайтад мэдээлэл байршуулсан. Чанар, стандартын шаардлага хангаагүй шахмал түлш борлуулах үйл ажиллагааг таслан зогсоож, эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажилласан.

Агаарын бохирдлыг бууруулах талаар авсан арга хэмжээ

ЭМЯ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НЭМҮТ, НЗДТГ-тай хамтран "Түүхий нүүрсний хор уршгийг иргэдэд таниулах өдөрлөг"-ийг Сүхбаатарын талбайд зохион байгуулж иргэдэд агаарын бохирдлын эх үүсвэр, сөрөг үр дагаврын талаар мэдээлэл сурталчилгаа хийлээ.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 560.0 сая төгрөгийн санхүүжилтээр авто тээврийн шалган нэвтрүүлэх иж бүрэн, явуулын 4 хяналтын цэг, түүнд ажиллах 24 эргүүл, хяналтын ажилтны төсвийг шийдвэрлэж, 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Nissan leaf маркын бүрэн цахилгаан авто машин худалдан авч Улаанбаатар хот руу зөвшөөрөлгүйгээр түүхий нүүрс болон хууль бус тээвэрлэлтийн үйл ажиллагаанд 24 цагаар тасралтгүй хяналт тавьж ажиллаж байна.

Агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч 5388 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, 2210 мэдэгдэл, зөвлөмж, албан шаардлага хүргүүлж, илэрсэн зөрчилд үндэслэн нийт 179 сая 150.0 мянган төгрөгийн торгууль ногдууллаа.

Үүнээс нүүрс тээвэрлэх зөвшөөрөлгүйгээр Улаанбаатар хот руу нэвтрэхийг завдсан 236.58 тн түүхий нүүрсийг улсын байцаагчийн 29 актаар хураан Амгалан дулааны станцид хүлээлгэн өгч, 2200.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.

Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэгч Улаанбаатар цэвэр агаар төсөл, Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл, Япон улсын Комотек корпораци, Олимпиус когия компани, JCM /Хамтарсан кредит олгох механизм/, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Агаарын бохирдолтой тэмцэх газартай хамтран ажиллаж, 15 сая төгрөгийн санхүүжилтээр Тесто багажийг ашиглалтад оруулж, халаалтын зуухны хаягдал утааны хэмжилт бие даан хийх нөхцөлөөр хангах, 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр агаарын хяналтын улсын байцаагчдын шатахууны зардал, 15 сая төгрөгийн санхүүжилтээр агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр гарын авлага тараах материал, “Агаар бохирдуулагч суурин эх үүсвэр ашиглагчдын байршлын зураглал /атлас/ хийх” асуудлыг шийдвэрлэлээ.

Нийт 1080 объектод цахилгаан халаагуур тавиулж, 1561 объект зуухыг сайжруулсан зуухаар солиулж, жилд түлэх түүхий нүүрсний хэмжээг 6000-6200 тн-оор бууруулж, хүрээлэн буй орчны агаарт 650-700 тн, 72.1-74.5тн хүхрийн давхар исэл, 27.9-28.83тн азотын ислүүд, 46.1-47.67тн PM10 тоосонцор, 274.1-283.2тн угаарын хий хаягдахаас урьдчилан сэргийллээ.

Нийслэлийн Засаг даргын санхүүжилтээр авсан дронеор “Таван толгой түлш” ХХК-ийн шахмал түлшний 1 дүгээр үйлдвэрийн зураглал, Баянзүрх, Согинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар 8 байршлаас агаарын бохирдлын зураглал хийж 2018 оны өвлийн улиралтай харьцуулан байгууллагын вэб сайтад байршуулан олон нийтэд мэдээллээ.

1.2. ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

2019 онд 2754 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр олон нийтэд зарласнаас 2590(94.0%) объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. Зөвлөн туслах үйлчилгээний явцад илэрсэн зөрчил, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан 2871 зөвлөмж боловсруулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн ажилласан.

Хүрсэн үр дүн: Зөвлөн туслах үйлчилгээг хяналтын хуудсаар хийж цахим системд бүртгэлжүүлсэн нь зөвлөн туслах үйлчилгээний үр дүнг тооцох, эрсдэлийн түвшинд дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүллээ. /Хавсралт 1- График 1/

1.3 ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ТАЛААР

2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 30 тандалт судалгаанаас 30 (100%) тандалт судалгааг 676 объектод хийж, үр дүн, танилцуулгыг МХЕГ-т хүргүүлсэн.

Хүрсэн үр дүн: Тандалт судалгааны үр дүнд хяналтын чиглэл бүрээр суурь судалгаатай болж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, төлөвлөлтийг зөв оновчтой хийх нөхцөл бүрдсэн.

1.4 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААР

2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 15 хяналт шинжилгээнээс 15 (100%) хяналт шинжилгээг 325 объектод хийж дуусгасан.

Хүрсэн үр дүн: Бүтээгдэхүүн, дотоод гадаад орчны аюулгүй байдлын түвшинг лабораторийн шинжилгээнд тулгуурлан тогтоосноор ард иргэд аюулгүй байдлын болон чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангагдах эрсдэл буурсан.

1.5 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТЫН ТАЛААР

2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 48 урьдчилан сэргийлэх хяналт хийхээс 47(97.9%) хяналтыг хийсэн.

Хүрсэн үр дүн: Нийслэлийн хүн амыг хоолны хордлого, хордлогот халдвар, мал амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин, гадаад орчны аюулгүй байдлаас үүсэх эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлж ажилласан байна.

1.6 САЛБАРЫН СУРГАЛТЫН ТАЛААР:

2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 35 салбарын сургалтаас 35 (100%) зохион байгуулсан.

Хүрсэн үр дүн: Хууль тогтоомж, стандарт, норм нормативын хэрэгжилт хангагдсан.

1.7 БАТАЛГААЖУУЛАХ ХЯНАЛТЫН ТАЛААР:

2019 онд 408 объектод 17(100%) баталгаажуулах хяналт хийгдсэн.

Хүрсэн үр дүн: Бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг сайжирч, бүтээгдэхүүний үйлчилгээний чанар дээшилж, эрсдэл буурсан үзүүлэлттэй байгаа нь сургалтын үр дүн юм.

1.8 ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

2019 онд нийт 1248 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн байна. Хийсэн томоохон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаас дурдвал:

1.8.1. НЗД-ын 2019 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/20 дугаартай “Гахайн гоц халдварт Африкийн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” захирамжийн хүрээнд худалдааны 276, хоол үйлдвэрлэлийн 426, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 53, гахайн аж ахуйн 26, нийт 781 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж нийт 393649 кг гахайн мах, махан бүтээгдэхүүнийг битүүмжлэн лацдаж, хугацаа дууссан 121 кг гахайн махыг хураан авсан.

Шинжилгээний дүнгээр эрсдэлтэй гарсан 1554,3 кг гахайн мах, махан бүтээгдэхүүнийг устгасан. Мөн 137 аж ахуй нэгж, иргэний гарал үүсэл нь тодорхойгүй, хугацаа дууссан, шинжилгээний дүнгээр эерэг гарсан нийт 7773.5 кг гахайн мах, махан бүтээгдэхүүн, гахайн аж ахуйн эрхлэгч 28 өрхийн 1083 гахай, гахайн сэг зэм, хүүрийг устгаж, ариутгал халдваргүйтгэл хийхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

1.8.2. НМХГ-ын дэд даргын баталсан 02-02-106 дугаартай “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх” тухай удирдамжийн хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах олон үндэстний хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг газрууд болон гахай, тахиа, загас, далайн гаралтай бүтээгдэхүүн нийлүүлдэг ханган нийлүүлэгч, агуулах, худалдааны 15 аж ахуйн нэгж, 20 иргэн нийт 35 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 02-01/68, 02-01/46 тоот мэдэгдлийг хүргүүлж ажиллалаа. Шалгалтаар 79 зөрчил илрүүлж, 59 буюу 22.3%-ийг газар дээр нь арилгуулж, улсын байцаагчийн 50 заалт бүхий 12 хугацаатай албан шаардлага, 8 албан даалгавар хүргүүлж, 3 аж ахуйн нэгж, 3 иргэний зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 8500,0 мянган төгрөгний торгуулийн арга авч бүрэн барагдуулж ажиллалаа.

1.8.3. “Таван богд фүүдс” ХХК-ийн “KFC-Зайсан” салбарын хоолны газарт хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328 тушаалаар баталсан “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журам”-ын дагуу ХӨСҮТ-тэй хамтран үүсгэгч, өвчний эх уурхай, дамжсан замыг тодорхойлох, халдвар тархахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хариу арга хэмжээг авч, “Зайсан KFC” салбарын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, 18 нэр төрлийн 5960 ширхэг, 31.1 кг амталсан, амтлаагүй тахианы мах, бэлэн боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнүүдийг устгуулан, ажлын байранд нь халдваргүйтгэлийг хийлгүүлсэн.

НМХГ-ын даргын баталсан 2019 оны 02-01/73 дугаартай “KFC сүлжээ хоолны газруудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд “Таван богд фүүдс” ХХК-ийн KFC-н бусад 11 салбар сүлжээ хоолны газруудад хамтарсан хяналт шалгалт хийж, 64 зөрчил, дутагдал илрүүлж 24 буюу 37.5 хувийг арилгуулж ажиллалаа. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 7 албан шаардлага, 5 албан даалгавар хүргүүлж, “Хоол хүнсээр дамжих өвчин гарсантай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу 14 сая төгрөгийн шийтгэлийг оногдуулан, 8.500.550 төгрөгийн хууль бус орлого, 49 сая 407 мянган төгрөгийн хохирол нөхөн төлбөрийг бүрэн барагдуулж, 2 салбарт 2000.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, холбогдох албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Хяналт шалгалтын явцад “Зайсан KFC”, “Зайсан пицца” салбарын усан хангамжийг нийлүүлэгч “Си Си Эс Эм Жи Эл” ХХК-ийн үйл ажиллагааг шалгахад зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр гүний худаг ашиглаж үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус түгээж байсныг тогтоон, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 5 сая төгрөгийн шийтгэл болон 15 сая төгрөгийн нөхөн төлбөр оногдуулж, худгийн ашиглалтыг зогсоох арга хэмжээг авч ажилласан. Нийт 9 ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх зөрчилтэй дэвтрийг хүчингүй болгож, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд давтан хамруулах арга хэмжээг авч, үзлэг шинжилгээнд хамрагдаагүй ажилтны эрүүл мэндийн дэвтэрт дардас дарж баталгаажуулсан Сонгинохайрхан дүүргийн нэгдүгээр салбар амбулаторийн эрхлэгчид сахилгын шийтгэл оногдуулах саналыг

байгууллагад нь хүргүүлэн, хуурамч дэвтэртэй холбоотой зөрчлийг шалгуулахаар харьяаллын дагуу Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

1.8.4. МХЕГ-ын дэд даргын баталсан 01/129 дугаартай “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулж буй хувийн гүний худагтай байгууллага, аж ахуйн нэгж, иргэний гүний худгийн ашиглалт, усны чанар аюулгүй байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж байна. Шалгалтад “Грийн вилла”, “Сөүл роял каунти”, “Анома”, “Энхжин”, “Женерал таун”, “Могоул таун”, “Хан түшээ”, “Зайсан Голден вилла” зэрэг 30 гаруй хотхоныг хамруулан, 27 гүний худаг, 40 усны нөөцийн сав, 32 хэрэглэгчийн /айл өрх, үйлчилгээ/ шугамын уснаас нийт 212 дээжийг авч, НМХГ, МХЕГ-ын лабораторид нян судлал, химийн үзүүлэлтээр шинжилгээ хийлгэсэн. Шинжилсэн нийт 99 дээжийн 8 (8%) нь нян судлалын үзүүлэлтээр, 3(3%) нь химийн үзүүлэлтээр стандартын шаардлага хангахгүй гарсан. Тухайлбал, гүний худгийн 27 дээжинд хими, нян судлалын үзүүлэлтээр 4 гүний худгийн усанд (14%) нянгийн тоо, 2 худгийн усанд (7%) хатуулаг, ус нөөцлөх савнаас авсан 40 дээжийн 2(5%)-т нянгийн тоо, 1(2.5%) дээжинд нитрат, хэрэглэгчийн цэгээс авсан 32 дээжийн 2(6%) дээжинд нянгийн тоо үзүүлэлтээр тус тус стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү хэмжээтэй илэрсэн байна. Усны чанар, аюулгүй байдлыг хангуулах талаар улсын байцаагчийн дүгнэлт 22, албан шаардлага 3, албан даалгавар 3-ыг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Нийт 3 аж ахуйн нэгж, 3 иргэнд нийт 8.5 сая.төгрөгийн шийтгэлийг ногдуулсан.

1.8.5. “Томуу, томуу төст өвчний үед эмнэлгүүдийн бэлэн байдал хангагдсан эсэх”-д төрөлжсөн болон тусгай мэргэжлийн эмнэлэг, ӨЭМ төвүүд буюу 47 эмнэлгийг хамруулан шалгаж, хүчинтэй хугацаа дууссан эмээр үйлчилсэн, эм, эмнэлгийн хэрэгслийг стандартын шаардлагын дагуу хадгалаагүй, “эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэж буй мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн бүртгэл хөтлөгдөөгүй, хог хаягдлын компанид хүлээлгэн өгөх хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг тусгаарлан хадгалаагүй зэрэг зөрчлүүдийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 2 аж ахуйн нэгжид 1.500.0 мянган төгрөг, 2 иргэнд 350.0 мянган төгрөгийн шийтгэлийг тус тус оногдуулж, 7 нэрийн 10 цувралын, 31 ширхэг 45.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг улсын /ахлах/ байцаагчийн 2 актаар хурааж, устгуулахаар Нийслэлийн орон тооны бус зөвлөлд шилжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

1.8.6. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам Хан-Уул дүүргийн Засаг даргын 2019 оны А/120 тоот “Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малтай өрхийн малыг зөвшөөрсөн бүсэд нүүлгэн шилжүүлэх тухай” захирамж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны “Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бүсийн хил хязгаарыг шинэчлэн батлах тухай” 21/06 тоот тогтоолын хэрэгжилтэд мал эмнэлгийн улсын байцаагчид хяналт тавьж ажилласан.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны “Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бүсийн хил хязгаарыг шинэчлэн батлах тухай” 21/06 тоот тогтоолын хүрээнд Сүхбаатар дүүргийн 133 толгой малыг, Хан–Уул дүүргийн 21 өрхийн 322, Сонгинохайрхан дүүргийн 18 өрхийн 239, Баянзүрх дүүргийн 1 өрхийн 23 толгой мал, нийт 40 өрхийн 584 толгой малыг хориглосон бүсээс мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүс болон орон нутаг руу нүүлгэн шилжүүлсэн байна.

1.8.7 НМХГ-ын даргын баталсан удирдамжаар нийслэлийн төвийн 6 дүүрэгт төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа явуулж байгаа нийт 10 иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмшлийн байдалд хяналт шалгалт хийхэд нийтийн эзэмшлийн зам, талбайд хаалт байршуулж, төлбөртэй авто зогсоолын үйл ажиллагаа явуулан эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газар ашигласан Эс би төв, Шөнийн зах худалдааны төв, Сандэй худалдааны төв, Гранд плаза худалдааны төв, Макс молл худалдааны төв, Цэцэг төв, Техник импорт ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн гаргасан зөрчилд 7000.0 мян төгрөгийн торгууль ногдуулан, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

Мөн “Сарны титэм үзэсгэлэн” ХХК, “Сүмт өргөө” ХХК, “Ди эйч эл” ХХК, “Драгон холдинг” ХХК, Орон зай худалдааны төв, Алтжин бөмбөгөр худалдааны төв, Тэди худалдааны төв зэрэг аж ахуйн нэгжүүд нь өөрийн эзэмшил газарт гэрээнд заасан зориулалтын бусаар ашиглаж, төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа явуулж байх тул улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага, мэдэгдэл хүргүүлэн ажиллалаа. Нийслэлийн нутаг дэвсгэрт эзэмшил газрынхаа орчныг бохирдуулж, доройтуулсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2-оос дээш жил ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийж, 116 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг цуцлуулах тухай саналыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн.

1.8.8. Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12/А/51 тоот “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай” хамтарсан тушаал, НЗД-ын А/224 дүгээр “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн хэрэгжилтийн хүрээнд НМХГ-ын дэд даргын баталсан хуваарийн дагуу тус газрын 15 байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчид ногоон бүс, алслагдсан дүүрэг хороодын нутаг дэвсгэрээр нийт 35 удаагийн хяналт шалгалтыг хийлээ.

Энэхүү ажлын хүрээнд тухайн нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэж буй байгаль хамгаалагчдын ажил байдлыг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, үүрэг чиглэл өгч, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэж хэвлэсэн мэдэгдэл, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг нийт 900 ширхгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад тарааж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж, сэрэмжлүүлэг бэлтгэж, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 65 удаагийн мэдээлэл явуулж, 1 удаагийн телевизийн шууд нэвтрүүлгээр мэдээлэл хийх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар 2 самбарыг бэлтгэж,

СХД-ийн Баруунтуруун, Баруун салаа зэрэг 2 байршилд байршуулах зэргээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

1.8.9. Налайх дүүрэгт нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж буй 6 нөхөрлөлийн 41 уурхайн аманд ажиллаж буй 460 иргэдийг хамруулан, НМХГ-ын дэд даргын баталсан удирдамжаар шалгалт хийж, 94 зөрчил илрүүлэн (46,8%) буюу 44 арилгуулан, хугацаатай 36 заалт бүхий 6 албан шаардлагыг хүргүүлэн, Зөрчилтэй 2 нөхөрлөлийн үйл ажиллагааг улсын ахлах байцаагчийн актаар түр хугацаагаар зогсоосон. Түүнчлэн тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд хууль бусаар нүүрс олборлож байсан 32 иргэний тоног төхөөрөмжийг лацдаж үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан.

1.8.10. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Тээврийн цагдаагийн албаны замын цагдаагийн газар, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын дарга нарын хамтран баталсан “Замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу дээрх байгууллагуудын албан тушаалтнуудтай хамтран шугам замд хяналт шалгалт хийв. Шалгалтаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний их багтаамжийн 20 автобусны утааны тортогжилтын хэмжээнд шалгалт хийхэд 14 автобусны утааны тортогжилтын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байсан тул зөрчлийг арилгуулах талаар 4 аж ахуйн нэгжид албан даалгавар хүргүүлж, “Дюц” ХХК-д 500.0 мян.төгрөгийн торгууль ногдуулж барагдуулав.

1.8.11. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дугаартай албан даалгавар, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан “Нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай” А/97 дугаартай тушаалын хүрээнд холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудтай хамтран “хяналт шалгалт хийх хуваарь”-ийн дагуу нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний “7-н буудал”, “Чингэлтэй”, “Хайлааст”-ын автобусны буудлын эцсийн зогсоол дээр 4 удаа хяналт шалгалт гүйцэтгэж, 400 гаруй том оврын автобусны техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөл хангасан байдал, “Сутайн буянт” ХХК, “Тэнүүн огоо” ХХК, “Эрдэм транс” ХХК, “Автотерминал трейд” ХХК, “Атибус” ХХК-иудын автобус угаалгын газрын байдлыг шалгаж, шалгалтын дүнг хэлэлцүүлэв.

Хяналтын байгууллагын хүнс болон орчны аюулгүй байдлыг хангуулах үйл ажиллагааг хараат бус, үнэн бодит шинжилгээний дүнгээр баталгаажуулж, дэмжлэг үзүүлнэ.

1.9 ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

2019 онд нийт МХЕГ-аас батлагдсан төлөвлөгөөт болон байгууллагын удирдамжтай, төлөвлөгөөт хяналт шалгалтын, аж ахуйн нэгж байгууллагуудын хүсэлтийн шинжилгээ, хордлого гомдлын нийт 22548 сорьцод 63588 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 1769 сорьц буюу 7.8% нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна. Өмнө оныхтой харьцуулахад эрүүл ахуйн шаардлага хангаагүй сорьцын тоо 0.7%-иар буурсан байна.

~~Энэ оны тоон мэдээг задалж харуулбал:~~ Хими, хор судлалын лабораторийн шинжилгээгээр нийт 9195 сорьцыг 28336 үзүүлэлтээр шинжлэхэд 153 сорьц буюу 1,6% эрүүл ахуйн стандарт шаардлага хангаагүй, ~~фарсан байна.~~ Микробиологийн лабораторийн шинжилгээгээр нийт 13353 сорьцонд 35252 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 1616 буюу 12.1% эрүүл ахуйн шаардлага хангаагүй, ~~фарсан байна.~~

Formatted: English (United States)

Нийт 582.570.350 төгрөгийн шинжилгээ хийгдсэнээс 328.311.020 төгрөгний орлогыг дансанд төвлөрүүлсэн бөгөөд 199.959.330 төгрөгний төлбөргүй шинжилгээ буюу удирдамжтай шалгалт, хордлого гомдол болон хүрээлэн буй орчны /хөрс, булаг, голын ус/ хяналтын шинжилгээ хийгдсэн байна. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн 1568 хүсэлтээр ~~дтүүлэн авч~~, 5986 ~~дээжинд~~ улсын байцаагчдаар ~~өрж ирсэн~~ шалгалтын 7384 ~~дээжинд~~, нийт 13370 дээжинд шинжилгээ хийсэн.

Formatted: Font color: Black

~~Хэвлэл мэдээлэл, цахим хуудсанд хүнсний аюулгүй байдлын талаар нийт 413 мэдээ мэдээлэл өгч, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл, сэрэмжлүүлгийг өөрсдийн page хуудас болон газрын web сайтаар хүргүүлж ажилласан.~~

Formatted: Font color: Black

~~99 ААН, иргэний 8-н төрлийн бүтээгдэхүүнд арга зүйн зөвлөмжийг хүргэсэн.~~

~~Яээ-~~

Formatted: Indent: First line: 0.25", Tab stops: Not at 0.39"

~~Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус шалгалтын явцад улсын байцаагчдын өгсөн 3724 дээжинд шинжилгээ хийлээ.~~

~~Нийт 139.997.611 төгрөгний өртөгтэй шинжилгээг лаборатори хийж гүйцэтгэснээс төсөвт 134.328.711 төгрөгийг төвлөрүүлж, 5.668.900 төгрөгний төлбөргүй шинжилгээ буюу удирдамжтай шалгалтын, хордлого гомдол болон хүрээлэн буй орчны /хөрс, булаг, голын ус/ хяналтын шинжилгээг хийсэн. Аж ахуйн нэгж, иргэдийн 878 хүсэлтээр 2542 дээжинд шинжилгээ хийсэн байна.~~

Лабораторийн чанар хангалт:

~~Сорилт шинжилгээний чанар хангах үйл ажиллагаанд "Сорилтын болон калибровкын лабораториудад тавигдах ерөнхий шаардлага ISO/IEC 17025"-ын дагуу чанарын тогтолцооны хэрэгжилтийг хангуулах зорилгоор Төв лабораторийн чанарын удирдлагын 17, техникийн шаардлагын 10, нийт 27 журам бүхий гарын авлагыг мөрдөж ажилласан.~~

Formatted: Tab stops: Not at 0.39"

~~Лабораторийн чанар хангалтын чиглэлээр шинжилгээний үр дүнг хянах, зөрүүг үнэлэх, арга аргачлалын харьцуулалт, баталгаажуулалтыг хийх зорилгоор ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг лабораториуд болох Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори, АПУ ХК, УСУГ-ын Усны Төв лаборатори, НЭМҮТ-ийн лабораториудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан..~~

~~Дээрх лабораториудтай нийт 10 удаа, 9 шинжээчийг 61 үзүүлэлтээр лаборатори хоорондын шинжилгээг хийлгэж, үр дүнг хянаж, зөрүүг үнэлсэн тайланг гаргасан.~~

Formatted: List Paragraph, List Paragraph1, Paragraph, IBL List Paragraph, List Paragraph Num, Дэд гарчиг, Heading Number, Bullets, List Paragraph (numbered (a)), Tab stops: Not at 0.39"

Шинжилгээний үр дүнг харьцуулсан 2 лабораториудын шинжилгээний үр дүн нь зөвшөөрөгдөх хязгаараас даваагүй, лаборатори хоорондын тохирц таарсан.

ХАБҮЛЛ-ийн ЭШСЭҮТ-ийн Ур чадварын сорилтын лабораториос илрүүлсэн 2019оны 1,2-р ээлжийн үр чадварын тестэнд нийт 16 шинжээч оролцсон.

АРЕС-ын олон улсын үр чадварын тестэнд 3-н үзүүлэлтээр шинжилгээ хийж, амжилттай хамрагдсан. Тестний үр дүнгээ Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (АПЕК) дэмжлэгтэйгээр Хятадын Хяналт, хорио цээрийн академийн шинжилгээний чадавхийг үнэлэх систем (ACAS)-д явуулаад байна.

Сорилт шинжилгээний чанар хангах үйл ажиллагаанд “Сорилтын бөлөн калибровжын лабораториудад тавигдах ерөнхий шаардлага ISO/IEC 17025”-ын дагуу чанарын төгөлдөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Төв лабораторийн чанарын удирдлагын 17, техникийн шаардлагын 10, нийт 27 журам бүхий гарын авлагыг мөрдөж ажилласан.

Лабораторийн шинжилгээний аргын үндэсний стандартуудад үзлэг хийж, “Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний нян шинжилгээний арга” стандартыг батлуулахаар ХАБҮЛЛ-тай хамтран техникийн хорооны эхний хуралдаанаар оруулсан

МХЕГ-ын ХАБҮЛЛ-иос илрүүлсэн 2019 оны 1-р ээлжийн үр чадварын тестэнд нийт 7 шинжээч оролцож хангалттай сайн үнэлгээ авсан.

Хөвлөл мэдээлэл, цахим хуудсанд хүнсний аюулгүй байдлын талаар нийт 178 мэдээ мэдээлэл өгч, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл, сөрөмжлүүлгийг ооредийн page хуудас болон газрын web-сайтаар хүргүүлж ажилласан.

51 ААН, иргэний 8 н төрлийн бүтээгдэхүүнд арга зүйн зөвлөмж мэдэгдлийг хүргэсэн.

Хүрсэн үр дүн: Итгэмжлэлийн хүчин төгөлдөр байдлыг хангаж, орчин, хүнсний бүтээгдэхүүний чанар стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээний түвшин баталгаажиж, чанартай хийж гүйцэтгэсэн.

Төв лабораторийн өдөр тутмын үйл ажиллагаа, шинжилгээний бөлөн байдал, чанар, үр дүн, лабораторийн ажиллагсдын үр чадвар, лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодисын чанар хангалтад дотоод хяналтыг тавьж ажилласнаар шинжилгээний технологийн алдаа гараагүй. Хяналтын шинжилгээг түргэн шуурхай гүйцэтгэж, ард иргэдэд шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх нөхцөл бүрдүүлсэн. Лабораториудын сорилтын үр чадварыг үнэлэх хөтөлбөрт 2 удаа хамрагдаж, хангалттай сайн үнэлгээ авч, лабораторийн шинжээчдийн шинжилгээ хийх үр чадвар сайн байгааг илтгэн харуулсан.

ХОЁР: ХУУЛИАР НИЙТЛЭГ ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй, шударга, шуурхай, ил тод байдлыг дээшлүүлэн, цахим системийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Formatted: Font: 11 pt

Formatted: Font: 11 pt

Formatted: Font: 11 pt

Formatted: Indent: First line: 0.25", Tab stops: Not at 0.39"

Formatted: Font: 11 pt

Formatted: Font: Not Bold, Font color: Custom Color(RGB(34,34,34)), Mongolian (Mongolia)

Formatted: Font color: Black

Formatted: Font color: Black

Formatted: Font color: Black

Formatted: Font: 11 pt

Formatted: Font: 11 pt, Not Italic

Formatted: Font: 11 pt

2.1. Төрийн захиргааны удирдлага, зохион байгуулалтын талаар:

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 143, Улаанбаатар хотын Ерөнхий Менежерийн 32, МХЕГ-ын цахим шуурхай хуралдааны 92, НМХГ-ын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний 269, нийт 536 үүрэг даалгаврын биелэлтийг 100% биелүүлэн ажилласан.

НМХГ-ын даргын дэргэдэх Зөвлөлийн 16 удаагийн хурлаар 43 асуудал хэлэлцэж, гарсан шийдвэрүүдийн хэрэгжилт дунджаар 74 хувьтай байна.

“2019 онд хийх хяналт шалгалтын календарчилсан төлөвлөгөө”, “НМХГ-аас МХЕГ болон төрийн бусад байгууллагуудад мэдээ, тайлан, төлөвлөгөөний биелэлт хүргүүлэх хуваарь”, “НМХГ-ын 2019 онд хийх сургалтын календарчилсан төлөвлөгөө” болон НМХГ-ын хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн эмхэтгэлийг гаргаж, дотоод үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Удирдах ажилтан, улсын байцаагчдын ажлын хариуцлага, сахилга, гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх зорилгоор удирдах ажилтан, улсын байцаагч, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг шинэчлэн НМХГ-ын даргын тушаалаар батлан, сар, улирал, хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийг дүгнэн хариуцлага тооцон ажиллав.

Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү, хяналт шалгалтын ил тод байдлыг ханган, цахим хуудас, шилэн данс, шилэн хяналтын цахим систем, мэдээллийн самбарт мэдээ мэдээллийг сар бүр шинэчлэн оруулсан.

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд НМХГ-ын байр, 6 дүүрэг дэх МХХ, Төв лаборатори, гаалийн бүс дэх 13 ажлын байр зэрэг 21 ажлын байранд саналын хайрцгийг байрлуулж, иргэдээс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ирүүлсэн 47 саналыг хүлээн авч судлан, үйл ажиллагаандаа тусган ажилласан.

2018 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж, “Зөрчилгүй, стандарт” дүгнэлт авсан.

Хүрсэн үр дүн: Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдал дээшилсэн.

2.2. Хүний нөөцийн үйл ажиллагааны талаар:

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах 2019 оны үр дүнгийн гэрээ/ гүйцэтгэлийн гэрээ/-г боловсруулж батлуулсан.

Нийт 390 албан хаагчид ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ, Нууцын баталгааны батламж, ашиг сонирхлын гэрээ, 110 төрийн үйлчилгээний ажилтантай хөдөлмөрийн гэрээ, нийт албан хаагчидтай ёс зүйн болон хариуцлагын гэрээг тус тус байгуулсан.

“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Төрийн албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хангуулсан.

Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд НМХГ-ын даргын А/08 дугаар тушаалаар нийт албан хаагчдын цалин, төрийн алба хаасан хугацааны, ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоосон.

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдлийн өнөөгийн байдлыг тодорхойлох, санхүүгийн тооцоолол болон албан хаагчдын хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэрт НМХГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг үзлэг хийж, нийт 187 албан хаагчдад зэрэг дэвийг шинээр болон хувийг нэмэгдүүлэн олголоо.

НМХГ-ын даргын 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/11 тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж албан хаагчдын 30 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлөөр батлуулахаар Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт холбогдох эрх зүйн баримт бичгийг хүргүүлсэн. ~~“Төрийн байгууллагын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” – т хамрагдаж, 04.1хувьтай “БҮРЭН ХАНГАЛТТАЙ” үнэлэгдсэн.~~

Түүнчлэн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланд нийт 498 албан хаагчдын хувийн мэдээллийг бүртгэлжүүлэв. Нийт 516 албан хаагчдын төрийн албан хаагчийн судалгаагаар мэдээллийн сан үүсгэсэн.

2019 онд 40 улсын /ахлах/ байцаагчийн эрх цуцлуулах, 50 улсын /ахлах/ байцаагчийн эрх олгуулах, 211 улсын /ахлах/ байцаагчийн эрх сунгуулах саналуудыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Шинээр томилогдсон 66, ажлаас чөлөөлөгдсөн 57 албан хаагчийн Нийгмийн даатгалын дэвтэрт, 323 албан хаагчийн эмнэлгийн хуудсанд тус тус бичилт хийж, “Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” тушаалын дагуу 492 ажилтан, албан хаагчийн ээлжийн амралтын мэдэгдлийг өгч биеэр эдлүүлээд байна.

Хүний нөөцийн асуудлаар 426 өргөдөл, 186 албан бичгийг хугацаанд нь 100% шийдвэрлэн, 473 албан бичиг боловсруулан иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлэн хариуг erp.ulaanbaatar.mn програмд орууллаа.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын шинээр томилогдох, сэлгэн шилжүүлэх, 62 албан хаагчийн Ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг холбогдох баримт бичгийн хамт Авилгатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан.

Байгууллагын хэмжээнд сул орон тооны захиалгыг 3 удаа байгууллагын цахим хуудсаар мэдээлсэн.

Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын болон барилгын техник, байгаль орчин, боловсрол, геологи уул уурхай, хэмжил зүй, тээвэр, эрүүл ахуйн хяналтын 33 улсын байцаагчийн ажлын байрны захиалгыг албан бичгээр хүргүүлж, олон нийтэд зарласан.

Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд буцалтгүй тэтгэмж 31 албан хаагчдад 4650000 төгрөг, 1 улсын байцаагч өвчний улмаас нас барсан тул 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгож, 2019 онд 14 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах бөгөөд 12-36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг нь төсөвт суулгасан. Тус байгууллагад ажиллаж байсан үе, үеийн ахмад буурлуудаа Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран Тамгын газар, Чиглэлийн хэлтэс, төв лабораторийн 230 албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан.

2019 онд Төрийн дээд одон медаль, МХЕГ, НМХГ, нутгийн захиргааны болон салбарын бусад шагналаар 389 албан хаагчийг шагнаж урамшууллаа.

Байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд нийслэл хотыг цэцэрлэгжүүлэх, эмзэг бүлгийн иргэдэд тусламж үзүүлэх арга хэмжээнүүдэд нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцсон.

- Төрийн албан хаагчийн ёс зүй манлайлал, сахилга хариуцлагын талаар

Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах ажлын хүрээнд удирдах ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар дүгнэн, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 26 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, давхардсан тоогоор 721 албан хаагчид анхааруулах хуудас өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн дагуу НМХГ-ын даргын 2019 оны А/13 дугаартай тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулан, 26 улсын /ахлах/ байцаагчид холбогдох 17 гомдлыг 4 удаагийн хурлаар хэлэлцүүлж, 15 улсын /ахлах/ байцаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн.

Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 5 чиглэлийн болон 6 дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүдэд нийт 192 улсын /ахлах/ байцаагч, албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

2.3. Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх талаар

“НМХГ-ын 2019 онд хийх сургалтын календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу чиглэлийн болон дүүрэг дэх МХХ-үүдээс албан хаагчдад 315 дотоод сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2405 албан хаагчийг хамруулсан. Япон, Солонгос, Испани, Франц, БНХАУ, БНЧУ, АНУ, Израйль, Украин, ХБНГУ, БНБУ, БНТУ, ОХУ зэрэг 13 улсад зохион байгуулагдсан богино, дунд хугацааны сургалтад 31 удаагийн сургалтанд 35 албан хаагч оролцсон.

“Мэдээллийн цаг” хөтөлбөрийг 3 удаа зохион байгуулж, 1200 албан хаагчийг хамруулан, “Төрийн албаны тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн талаар мэдлэг, мэдээлэл олгосон.

Хүрсэн үр дүн: Хүний нөөцийн чадавх сайжирсан. Мэдээллийг “Able cloud” программд оруулснаар үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж, ажлын хариуцлага, сахилга, дэг журам сайжирсан.

2.4. Мэдээлэл технологийн чиглэлээр:

НМХГ-ын албан хаагчдын дотоод сүлжээ, компьютер техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хуваарь гаргаж, засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн. Албан хаагчдад шинээр 70компьютер, 15 принтер техник хэрэгслийг суурилуулан хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Албан хаагчдын 218 компьютер, 85 принтерт засвар үйлчилгээ хийж, чиглэлийн болон дүүргүүд дэх МХХ-ийн epg.ulaanbaatar.mn цахим программд нэвтрэх эрх үүсгэсэн.

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 22, НМХГ-ын даргын зөвлөлийн хурал 16, МХЕГ-ын цахим хурал 22, НМХГ-ын үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээ байгуулах үйл ажиллагааны техник хэрэгслийг холбож хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн нэгдсэн тогтолцоо бий болгох ажлын хүрээнд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас Гүний гаалийн 13 терминалын байршил, үйл ажиллагааг болон бусад шаардлагатай мэдээллийг газар зүйн мэдээллийн системд суурилуулж, дундын мэдээллийн санд гахайн мялзан өвчний мэдээллийг байршуулан, 13 терминалын байршлыг “What3words”-ын хаягжилтаар төслийн нэгжид хүргүүлсэн.

Хүрсэн үр дүн: Дотоод сүлжээний холболт болон компьютер, техник хэрэгсэлд шаардлагатай засвар үйлчилгээг тухайн бүр хийж, техникийн хэвийн үйл ажиллагааг хангаснаар байгууллагын ажил хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлсэн.

2.5. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажил, үр дүнг олон нийтэд сурталчилсан талаар:

“Байгууллагын ил тод байдал”-ын төлөвлөгөөг батлуулан, биелэлтийг хангуулан ажиллалаа.

НМХГ-аас 7 хяналтын чиглэлээр 25 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, 410 сэдвийн мэдээ мэдээллийг 2039 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, олон нийтэд хүргэлээ. Үүнээс телевизээр 1197, FM радиогоор 89, мэдээллийн вэб сайтуудаар 559, өдөр тутмын сонин хэвлэлээр 191 удаа мэдээ мэдээлэл түгээсэн. Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоотой санамж бичиг байгуулж хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн. Арслан.mn вэб сайттай мониторинг дүн шинжилгээ хийх, мэдээ мэдээлэл түгээх талаар өдөр тутамд хамтран ажилласан.

Байгууллагын цахим хуудсанд зөрчлийн мэдээ 917, зөвлөмж 2168, сэрэмжлүүлэг 73, сургалтын мэдээ 233, бусад мэдээлэл 118, нийт 3610 мэдээ мэдээлэл байршуулсан.

“Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар” пэйж хуудасны дагагчийн тоо 43302-т хүрч, 19958-аар нэмэгдлээ.

Хүрсэн үр дүн: НМХГ-ын үйл ажиллагаа, хяналт шалгалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах үйл ажиллагаа ил тод нээлттэй болж, удирдлага, иргэд олон нийт мэдээллээр хангагдсан.

2.6. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

Байгууллагын баримт бичгийг хуулийн хүрээнд боловсруулах чиглэлээр НМХГ-ын даргын 563 тушаал, 633 албан бичиг, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан 32 гэрээний хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, давхардсан тоогоор 823 улсын байцаагчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн.

“Авлигын эсрэг хууль”, “Авлигын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 367 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд баталгаажуулан тайлан мэдээг МХЕГ-т хүлээлгэн өгч, их хэмжээний өөрчлөлтөөр 6 албан хаагчийн ХАСХОМ-ийг хянан баталгаажуулж, шинээр томилогдсон 52 албан хаагчийн ХАСХОМ-ийг цахим мэдээллийн санд бүртгэсэн.

НМХГ-ын даргын баталсан “Авлигын эсрэг 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсэг хяналт тавин ажиллаж, биелэлтийг хагас болон бүтэн жилээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар албан бичгээр хүргүүлсэн.

НМХГ-ын нийт албан хаагчдад АТГ-тай хамтран “Мэдээллийн цаг”-аар “Шинэ үеийн төрийн алба”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ёс зүй, ашиг сонирхлын зөрчил” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Байгууллагыг хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын хүрээнд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх 26, иргэний хэрэг шийдвэрлэх 4, нийт 30 ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан.

Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан эд зүйл, бараа бүтээгдэхүүнийг улсын орлого болгох, устгах ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Нийслэлийн зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд хууль тогтоомж зөрчсөн, стандартын шаардлага хангаагүй 97 нэр төрлийн 53.523.321 төгрөгийн үнэ бүхий 1524 ширхэг бараа бүтээгдэхүүнийг устгаж, /ахлах/ байцаагчдын 21 акт, Улаанбаатар хотын Гаалийн газраас ирүүлсэн 2 нэр төрлийн 448 ширхэг цагаан архийг СХД-ийн 26 дугаар хороон дахь Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт устгасан.

Хууль тогтоомжийн хэрэгжүүлэх, албан хаагчдын эрх зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зүйлс”, “Төрийн албан хаагчдад оногдуулах сахилгын шийтгэл”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Хавтаст хэргийн гэрэл зургийн үзүүлбэр” сэдэвт дотоод сургалтуудыг зохион байгуулж, 408 нийт албан хаагчийг хамруулсан.

Тайлант хугацаанд 2 хууль, 1 дүрэм журам, 1 стандартад санал өгсөн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасныг үндэслэн хүн хуулийн этгээд албан тушаалтнаас гаргасан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон

хяналт шалгалтаар илэрсэн 1938 зөрчлийг бүртгэн дугаар олгож, мэдээг сар бүрт нэгтгэн, улирал тутам Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт хүргүүлсэн.

Тус газрын чиглэлийн хэлтсийн эрх бүхий албан тушаалтнуудын зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ажиллагааны 1395 тэмдэглэлийг бүртгэж, шийдвэрлэлтийн мэдээг сар бүр Нийслэлийн Прокурорын газарт хүргүүлэв.

Хүрсэн үр дүн: Байгууллагын эрхзүйн орчин сайжирч, баримт бичгүүд хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагдаж, албан хаагчдын эрх зүйн мэдлэг чадварыг нэмэгдүүлж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн.

2.7. Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэл үр дүн:

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны төсвийг сар, улирлаар хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин зориулалтын дагуу зарцуулсан.

Тайлант хугацаанд нийт 6.616.022.9 мян төгрөгийн санхүүжилт батлагдаж батлагдсан төсвийн хүрээнд цалингийн зардалд 4,687,633.6 мян.төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 556,734,3 мян.төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 249,979.3 мян. төгрөг, хангамж бараа материалын зардалд 179,000.7 мян. төгрөг, норматив зардалд 59,903.2 мян.төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 21,377.0 мян.төгрөг, томилолт, зочны зардалд 1,865.0 мян. төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 37,284.9 мян.төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3,334,9 мян.төгрөг тус тус зарцуулж ажилласан.

Нийгмийн баталгааг хангаж ажиллах ажлын хүрээнд 32 албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж 26,790.1 мян.төгрөг, 4 албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 60,213.6 мян.төгрөгийг олгосон.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 437,168.3 мян.төгрөгийн санхүүжилт орж ирснээс Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлаас Нийслэлийн Засаг даргын захирамжаар 40,000.0 мян.төг төгрөг, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас 16,115.0 мян.төгрөг, Нийслэлийн Агаарын Бохирдлыг бууруулах газраас Нийслэлийн Засаг даргын А/644 тоот захирамжаар 30,000.0 мян.төгрөг, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас Нийслэлийн Засаг даргын А/497 тоот захирамжаар 2,600.0 мян.төгрөг, Нийслэлийн онцгой байдлын газраас Нийслэлийн Засаг даргын А/40 захирамжаар 5,450.0 мян.төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 1,039.5 мян.төгрөг, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газраас Засгийн газрын 62 дугаар тогтоолоор 279,300.3 мян.төгрөг тус тус орж ирснийг зориулалтын дагуу зарцуулж тухай бүрт тайлагнаж ажилласан.

2019 онд нийслэлийн төсөвт хүү, торгуулийн орлого 3,2 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 213%-тай, улсын төвлөрсөн төсөвт шинжилгээний орлого 301 сая төгрөг төвлөрүүлж 109%-ийн биелэлттэй ажиллалаа.

2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар нийт 16 хэлтсийн давхардсан тоогоор 3570 улсын /ахлах/ байцаагч нартай нийт 3,131,097.9 мян.төгрөгийн торгууль шийтгэвэрийн тооцоо нийлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/441 тушаалаар Агаарын чанарын хяналтын хэлтэст 21,500.0 мян.төгрөгийн бүрэн цахилгаан автомашин, 15,590.0 мян. төгрөгийн Нисдэг камерын багц, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Багануур дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст 19,700.0 мян.төгрөгийн үнэ бүхий “Тоёота Приус-30” маркийн суудлын автомашин, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/460 дугаар захирамжаар Мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх ажлын хүрээнд 155,000.0 мян.төгрөгийн үнэтэй 8 ширхэг Приус-30 маркийн суудлын автомашин, 118,866.0 мян.төгрөгийн компьютер 70 ширхэг, принтер 15 ширхэг, 46,266.0 мян.төгрөгийн бичгийн ширээ 90 ширхэг, сандал 91 ширхэг, шкаф 1 ширхэг, 13,508.0 мян.төгрөгийн 4 ширхэг дрон, 23,400.0 мян.төгрөгийн автоклав 2 ширхгийг тус тус худалдан авсаныг НМХГ-н даргын тушаалаар холбогдох данс бүртгэлд бүртгэсэн болно.

Хүрсэн үр дүн: Санхүүгийн сахилга хариуцлага дээшлүүлэхэд анхаарч, батлагдсан төвийн хүрээнд санхүүгийн нөөцийг зөв зохистой зарцуулан, ил тод байдлыг хангасан.

2.8. Хяналт шинжилгээ, үнэлгээний талаар:

НМХГ-ын даргын баталсан удирдамжаар Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, Дэд бүтцийн хяналтын хэлтэс, Багануур дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалт хийсэн. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлын дагуу нийт 100 улсын /ахлах/ байцаагчдын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн.

Тайлант хугацаанд нийт 13 бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

Хүрсэн үр дүн: Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт Мэргэжлийн хяналтын байгууллагатай холбоотой тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хангагдаж, эрчимжсэн.

2.9. Архивын үйл ажиллагааны талаар:

2019 онд нийт 14117 баримтыг архивт хүлээн авч, лавлагаа мэдээлэл хүссэн 99 албан бичиг, 31 өргөдлийг шийдвэрлэн 426 баримтыг хуулбарыг баталгаажуулж олгосон.

“Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, “Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”, “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам”-уудын биелэлтийг Нийслэлийн Архивын газарт албан бичгээр хүргүүлсэн.

Хадгалах хугацаа дууссан 2003-2012 оны 39 хэргийн 1215 хадгаламжийн нэгжийг бүртгэлжүүлж, 812 устгах хэргийн жагсаалт үйлдэж, Нийслэлийн Архивын газрын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хүрсэн үр дүн: Холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилласнаар байгууллагын архивын үйл ажиллагаа, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангагдсан.

2.10. Албан бичиг, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн талаар:

Тайлант хугацаанд НМХГ-ын хэмжээнд 16103 албан бичиг ирснээс хариутай 8880 албан бичгийн 7601(85,6%) хуулийн хугацаанд шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа 1125(12,7%), хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 148(1,6%) хугацаа хэтэрсэн 6 (0.1%) байна.

2019 онд 7864 гадагш явуулсан албан бичиг, 549 улсын байцаагчийн акт, 2227 албан шаардлага, 3590 дүгнэлт, 625 удирдамж, 2910 зөвлөмж, 381 хяналт шалгалтын танилцуулгад нэгдсэн дугаар олгогдсон байна.

Албан хаагчдад www.edoc.ub.gov.mn программыг бүрэн нэвтрүүлж албан бичгийн бүртгэл шилжүүлэлт, шийдвэрлэлтэд удирдах ажилтан, албан хаагч бүрээр 7 хоног, сар, улирлаар хяналт тавин ажилласан.

Хүрсэн үр дүн: Албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу явуулж, албан бичгийн нэгдсэн цахим программтай болсноор шийдвэрлэлтэд тавих хяналт сайжирсан.

2.11. Шуурхай албаны талаар:

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, шуурхай үйлчлэх зорилгоор Шуурхай албыг 24 цагаар ажиллуулж, 4191 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 4023(95.99%) асуудлыг шийдвэрлэсэн, 168(4.01%) нь шийдвэрлэх шатандаа байна. Нийт 39 осол, 16 хордлогын дуудлага хүлээн авч, МХЕГ-ын даргын 2015 оны 161 дүгээр тушаалын хавсралт хүснэгтийн дагуу тухай бүр холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн шийдвэрлэсэн.

Хүрсэн үр дүн: Шуурхай албаны байнгын бэлэн байдал хангагдаж, ослын үед холбогдох арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлсэн.

2.12. Эрсдэлийн төлөв байдал, эрсдэлийг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүнгийн талаар

НМХГ-ын хэмжээнд 2019 онд нийт 266 улсын /ахлах/ байцаагч 40 эрсдэлийн шалгуур, үзүүлэлтээр 44851 объектод эрсдэлийн үнэлгээ хийлээ.

МХБ-ын эрсдэлийн үнэлгээний мэдээллийн санд үндэслэн “Эрсдэлийн төлөв байдлын дүн шинжилгээний эмхтгэл”-ийг МХЕГ-тай хамтран боловсруулахаар хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлүүдээр дүн шинжилгээг хийсэн.

Шилэн хяналтын цахим систем”-ийн аж ахуйн нэгжийн порталыг аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчилахаар тараах материал, брошюруудыг бэлтгэн 350 гаруйг хэвлүүлж, “Эрүүл аюулгүй орчин-таны оролцоо” аяны хүрээнд аж ахуйн нэгж, иргэдэд тарааж сурталчилсан. ДБХХ-ийн хэмжилзүйн хяналтын улсын /ахлах/ байцаагчидтай хамтран Алтжин бөмбөгөр худалдааны төвд үйлчлүүлж байгаа иргэд, түрээслэгч нарт “Шилэн хяналтын цахим систем”-ийн аж ахуйн нэгжийн порталыг сурталчилж, 130 гаруй тараах материалыг тараасан.

Байгууллагын [/ub.inspection.gov.mn/](http://ub.inspection.gov.mn/) цахим системд Эрсдэлийн төлөв байдал, эрсдэлийг бууруулах чиглэлээр мэдээ, зөвлөгөө тогтмол тавьж ажилласан.

2019 оны зорилт, төлөвлөлтүүд, явц, биелэлт, эрсдэлийн үнэлгээ, удирдах ажилтан, улсын байцаагчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт, хяналтын хуудас, хэрэглэгчийн хяналтын хуудсыг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллага, иргэд татан авч, ашиглах, зөвлөгөө мэдээлэл авах хялбар нөхцөлийг бүрдүүлэн байршуулж олон нийтэд хүргэн ашиглаж байна.

Нийгэмд тулгамдсан тодорхой асуудлаар хэрэглэгчид чиглэсэн аян, мөн нийгэмд болон салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарцыг олох, төрийн төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор хийсэн хэлэлцүүлэг, уулзалт

Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт”, “Эрүүл аюулгүй орчин - таны оролцоо”, “Иргэн таны төлөө – Мэргэжлийн хяналт” аянуудыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, хууль тогтоомжийг сурталчилж, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа.

1. “Эрүүл аюулгүй орчин-таны оролцоо” сарын аяны хүрээнд өргөх байгууламжийн угсралт, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг 36 байгууллагын 57 удирдлага, инженер техникийн ажилтанд болон авто замын салбарын захиалагч, барилга угсралт, засвар арчлалт, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй болон бусад тусгай зөвшөөрөл бүхий 61 аж ахуйн нэгж байгууллагын 104 инженер техникийн ажилчдад тус тус сургалт зохион байгуулж, зурагт хуудас, сэрэмжлүүлэг 60 ширхгийг тараав.

“Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хууль бусаар тээвэрлэж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамж”-ийн дагуу “Глобал”, “Шинэ Монгол Харүмафүжи”, “Бритишн” сургуулиудын хүүхэд тээвэрлэдэг 28 автобусны техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөл хангасан байдлыг шалгаж, сургуулийн хүүхэд тээвэрлэгч жолооч нарт зөвлөмж тарааж автобусны бүхээгт байрлуулав.

2. “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сарын аяны хүрээнд байгаль орчны багц хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах, хууль сахин мөрдөлтийг дээшлүүлж төрийн хяналт шалгалтыг иргэдэд ойлгомжтой болгох, ААНБ-ын үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, соён гэгээрүүлэх чиглэлээр нийт 30 ажил төлөвлөн 100% хийж, 2335 гаруй тараах материал, гарын авлага зөвлөмж, сэрэмжлүүлэг, 1200 ширхэг танилцуулга, 300 ширхэг плакат хэвлүүлэн тараалаа. Мөн давхардсан тоогоор ТВ-ийн шууд нэвтрүүлэг 9, радио 6, сонин 8, байгууллагын сайт 93, бусад сайт- 6-д мэдээлэл өгч, хэвлэлийн хурал 1, хэлэлцүүлэг 1, үзүүлэх сургалтыг зохион байгуулсан.

3. “Иргэн таны төлөө - Мэргэжлийн хяналт” сэдэвт сарын аяны нээлтийг Ти-Ай-Ложистик ХХК дахь гүний гаалийн хяналтын бүсэд экспорт, импорт, хилийн хорио цээр, цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр нийт 120 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Сарын аяны хүрээнд 12 удаагийн сургалт зохион байгуулж,

138 байгууллагын 560 гаруй иргэнд хүнсний бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандарт, цацрагийн аюулгүй байдлын талаар 12 төрлийн зөвлөмж, 3 төрлийн шторк, 3 төрлийн гарын авлага тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн, 58 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. “Импортын эмийн чанар, аюулгүй байдал, анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, нийт 33 эм хангамжийн байгууллагын удирдлага, гаалийн менежер, эмийн мэргэжилтнүүдийг хамруулсан.

Нэг цонхны үйлчилгээнээс олгож буй гэрийн жижиг тэжээвэр амьтан, ахуйн хэрэгцээний мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ олголтын үйлчилгээний талаар санал асуулга авч, дүнг нэгтгэж, дүгнэлт хийсэн.

Импортын тахиа, шувууны маханд тандалт судалгаа хийж, БНХАУ-аас нийт 15 байгууллагын импортолсон тахианы ястай, ясгүй түүхий махны 76 дээжийг авч, цацрагийн шинжилгээнд хамруулсан байна. Олон нийтийн цахим сүлжээгээр цацрагтай байж болзошгүй хэмээн тархсан мэдээллийн дагуу 3 төрлийн матрас, сэрүүн дэр болон триагерц, турмалин, гартаам, нил эрдэнэ, усан болор, ногоон ундрам, анар зэрэг байгалийн чулуу, нанотехнологийн тусламжтайгаар бүтээсэн ээмэг, бугуйвч, хүзүүний зүүлтэд цацрагийн хэмжилт хийхэд байгалийн цацрагийн дэвсгэр түвшинд байсан.

Сарын аяны хүрээнд экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналт, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулах, хууль, дүрэм, журмыг сурталчлах зорилгоор НМХГ-ын цахим хуудас, фэйсбүүкт нийт 178 зурагт хуудас мэдээллийг байрлуулан, 5 телевизид 6 удаагийн ярилцлага зочны цаг нэвтрүүлэгт оролцон, сарын аяны талаар 3 телевиз, 1 радиод тус тус ярилцлага өгсөн.

Шилэн хяналтын системийн бүрдүүлэлт:

“Шилэн хяналтын цахим систем”-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг төлөвлөх, явц, гүйцэтгэл, үр дүнг удирдах үйл ажиллагааг системчлэн, статистик мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх, дүн шинжилгээ хийх мэдээллийн суурь баазыг байгуулан ашиглаж байна.

Шилэн хяналтын цахим системд 139468 объектыг бүртгэж, 44851 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, 4700 хяналт шалгалт, 2754 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 2019 онд давхардсан тоогоор 4659 (99.1%) хяналт шалгалт 2590 (19.1%) зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

НМХГ-ын хэмжээнд 676 объектод тандалт судалгаа, 325 объектод хяналт шинжилгээ, 7982 объектод урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт, 408 объектод баталгаажуулах үйл ажиллагаа, 1277 объектод салбарын сургалтыг зохион байгуулж бүртгэсэн байна.

Шилэн хяналтын цахим системд хяналт шалгалтын мэдээллийг бүртгэсэн явцыг сар бүр, улсын байцаагч, хэлтэс бүрээр 12 удаа гаргаж, НМХГ-ын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөр 3 удаа хэлэлцүүлж хуралдаанаас хэлтэс, улсын байцаагчдад 74 анхааруулах хуудас өгч, биелэлтийг тооцон ажилласан.

2019 оны шинэчлэн батлагдсан 120 хяналтын хуудсыг Шилэн хяналтын цахим системд угсарч хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашигласан.

Чиглэл болон дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүдэд шилэн хяналтын цахим системд мэдээлэл оруулах, гарсан алдааг засах сургалтыг 20 удаа зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

“Шилэн хяналтын цахим систем ашиглах тухай” улсын /ахлах/ байцаагчдад зориулсан гарын авлага, хэрэглэгчийн хяналтын хуудас ашиглах заавар, бусад хяналтыг бүртгэх видео хичээлийг цахим хуудсанд байршуулан улсын байцаагчид ашиглаж байна. Шилэн хяналтын цахим системд шинээр томилогдсон болон чөлөөлөгдсөн 18 улсын байцаагчдын өөрчлөлтийг хийсэн.

[Хяналтын хуудас, хэрэглэгчийн хяналтын хуудсыг сурталчлах талаар:](#)

Шадар сайдын 2014 оны 87 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратеги”-ыг НМХГ-ын цахим хуудас /ub.inspection.gov.mn/-д байршуулан эрсдэлийн удирдлага, төлөвлөлтийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж ажиллаж байна. “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт”, “Эрүүл аюулгүй орчин - таны оролцоо”, “Иргэн таны төлөө – Мэргэжлийн хяналт” сарын аяны хүрээнд хэрэглэгчийн хяналтын хуудсыг олон нийтэд танилцуулан мөн байгууллагын цахим хуудсанд байршуулан сурталчилж ажиллалаа. Аяны хүрээнд нийт 206 ш тараах материалыг аж ахуйн нэгж, иргэдэд тарааж сурталчилсан.

НМХГ-ын цахим хуудас болон иргэдэд үйлчлэх мэдээллийн төвд хяналтын хуудас, хэрэглэгчийн хяналтын хуудсуудыг байршуулан, олон нийтэд тогтмол сурталчилж байна.

Сүхбаатарын талбайд зохион байгуулсан “Засгийн газрын нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр болон Дэд бүтцийн хяналтын чиглэлээр зохион байгуулсан сарын аяны хүрээнд хэрэглэгчийн хяналтын хуудас сурталчлах зөвлөгөөг зохион байгуулсан.

[Эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд соён гэгээрүүлж, зөвлөн тусалж, хэрэглэгч, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажилласан талаар](#)

НМХГ-аас 2019 онд 14 төрийн байгууллага, 18 төрийн бус байгууллага мэргэжлийн холбоодтой хууль тогтоомжийн хангах чиглэлээр хамтран ажиллаж, хяналт шалгалтын давхардлыг бууруулах арга хэмжээг авлаа.

“Барилгын хөгжлийн Үндэсний төв”-тэй хамтран хамтран ажиллах санамж бичиг байгуулан, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо, БОАЖЯ, ЭМЯ, ЦЕГ, Авто тээврийн үндэсний төв, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, Тээврийн цагдаагийн газар, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, дүүрэг хороодын мэргэжилтнүүдтэй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хамтран ажилласан.

Дэд бүтэц, байгаль орчин, агаарын бохирдол, хүнсний аюулгүй байдал, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл ахуй, экспорт, импорт, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлүүдээр холбогдох салбаруудын “Худалдаа аж үйлдвэрийн

танхим”, “Нийслэлийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг”, “Азийн органик залуучуудын хөдөлгөөн”, “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих төв”, “Монголын шүдний мэргэжилтнүүдийн холбоо”, “Арьс ширний үйлдвэрүүдийн холбоо”, “Монголын барилгачдын холбоо”, “Монголын инженерүүдийн холбоо”, “Эрүүл ахуй, цацрагийн аюулгүй байдлын нийгэмлэг”, “Монголын цацрагийн хамгаалалтын нийгэмлэг”, “Улаанбаатар цэвэр агаар төсөл”, “ДЭМБ”, “Жайка ” ОУБ, “Японы Комомек корпораци ”, “Олимпиус Когия ”, “JCM”, “SGS”, “ИММЕлаборатори” зэрэг төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран олон нийтийг эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх, бизнесийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах талаар хамтран ажиллалаа.

Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэгч Улаанбаатар цэвэр агаар төсөл, Япон улсын Комотек корпораци, Олимпиус когия компани, JCM /Хамтарсан кредит олгох механизм/, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран, Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төслүүдийн хүрээнд хамтран ажиллаж байна.

НХХААГ, Азийн Органик залуучуудын хөдөлгөөн байгууллагын Монгол дахь салбарын гишүүдтэй хамтран “Шинэ Монгол Харүмафүжи” дунд сургууль болон 12 дугаар сургуулийн нийт 157 хүүхдийг хамруулан “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” MNS 6648:2016 стандарт болон “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”-ыг таниулах, сурталчлах, шошгыг хэрхэн зөв унших талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулсан.

Хүрсэн үр дүн: Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайжирч, хяналт шалгалтын давхардлыг арилгах, бизнес эрхлэгчдэд учрах хүндрэл бэрхшээлийг арилгах ажилд ахиц гарч, хууль сахин мөрдөлт сайжирсан.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор хийсэн ажил, сургалт, зөвлөмж, мэдэгдэл:

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “НМХГ-ын 2019 оны сургалт, зөвлөн туслах үйлчилгээний календарчилсан төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, нийт 6883 байгууллага, аж ахуйн нэгж, 1975 иргэнд 173 сургалтыг зохион байгууллаа. Сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас сэтгэл ханамжийн судалгааг авахад 72.2% нь сургалтыг 100% үр дүнтэй болсон гэж үнэлсэн.

2019 онд 29 хяналтын чиглэлээр 626 зөвлөмжийг 84403 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд, 831 мэдэгдлийг 32675 аж ахуйн ахуйн нэгж, байгууллагад тус тус хүргүүлж болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлж ажиллалаа.

Хүрсэн үр дүн Иргэдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил нь игэд, олон нийтийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрүүлсэн.

ГУРАВ: ДУГНЭЛТ, ҮР ДҮН

1. 2019 оныг "Иргэн төвтэй үр дүнд чиглэсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, бизнес эрхлэгчдийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдэлийг үнэлгээг илүү оновчтой хийх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, үр дүнгээ тооцон ажиллалаа.

2. "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" Засгийн газрын 2019 оны 62 дугаар тогтоол хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ЭМЯ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НЭМҮТ, НЗДТГ-тай хамтран "Түүхий нүүрсний хор уршгийг иргэдэд таниулах өдөрлөг"-ийг зохион байгуулсан, Нийслэлийн Засаг даргын захирамжаар НБОГ, НЭМГ, НЦУГ-тай хамтран "Нийслэлийн шуурхай штаб"-ыг 24 цагаар ажиллуулж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр шуурхай авч ажилласан, автотээврийн 3 шалган нэвтрүүлэх товчоо, маршрутын бус 4 хяналтын цэгүүдээр нэвтрэх тээврийн хэрэгслүүдийг 24 цагаар хянасан, нийслэл, дүүрэг дэх МХХ-ийн улсын нийт 372 байцаагч төвийн 6 дүүргийн 154 хороодын иргэдэд агаарын бохирдлыг бууруулах болон шахмал түлшний хэрэглээний чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан, "Таван толгой түлш" компанийн шахмал түлшний үйлдвэрлэлд хяналт тавьсан зэрэг нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийн бүрдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнд 2019 оны 11 дүгээр сарын дундаж өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад нарийн ширхэглэгт PM2.5 тоосонцор 43%-иар, том ширхэгт PM10 тоосонцор 42%-иар тус тус багасч, агаарын бохирдол, утааны хэмжээ мэдэгдэхүйц буурсан байна.

3. Тайлант хугацаанд "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-т хамрагдаж, 91,4 хувьтай дүгнэгдсэн нь НМХГ-ын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт шаардлагын төвшинд байгааг харуулсан үзүүлэлт болсон.

4. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн хүрээнд 400 сая төгрөгийн санхүүжилтээр хяналт шалгалтад шаардлагатай машин, компьютер, багаж, техник, хэрэгсэл худалдн авч материаллаг баазыг бэхжүүлсэн нь албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн томоохон арга хэмжээ болсон.

5. Зөвшөөрөлгүй, эзэмшил газрынхаа хэмжээг хэтрүүлэн газар эзэмшиж ашиглаж байсан иргэн, аж ахуйн нэгжийн хашааг татуулсан, нийтийн эзэмшлийн гарц, зам, талбай чөлөөлүүлсэн, сургууль, цэцэрлэг болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цахилгаан дамжуулах ил задгай утас, кабель, ухсан нүхийг булуулсан, барилгын хаалт хамгаалалт, бэхэлгээ хийлгэсэн, махны чанар аюулгүй байдлыг хангуулсан зэрэг нь

нийслэлийн өнгө үзэмж, орчныг тохижилтыг сайжруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангуулахад чиглэсэн арга хэмжээ болсон.

6. 2019 онд НМХГ-ын хэмжээнд 4700 төлөвлөгөөт шалгалт, 2754 төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 4659 (99.1%) төлөвлөгөөт шалгалт, 2590 (94.0) зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. /Хавсралт-1, График 1/

7. 2019 онд улсын байцаагчдын үйлдсэн албан шаардлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.0%-иар, торгуулийн хэмжээ 38.9%-иар, нөхөн төлбөр 2.2 %-иар, акт 3.9%-иар, дүгнэлт 19.8 %-иар, хурааж устгасан эд зүйлсийн дүн 1.7 дахин тус тус өссөн бол улсын орлого болгосон эд зүйлсийн дүн 10.8 дахин буурсан үзүүлэлттэй байна. /Хавсралт-2, График 4, 5, 7, 8, 9, Хүснэгт 1/

8. Зөрчил гаргасан 183 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, зөрчлөө арилгасан 86 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сэргээсэн нь өмнөх оноос үйл ажиллагааг түр зогсоосон аж ахуйн нэгжийн тоо 39.7%-иар, үйл ажиллагааг сэргээсэн аж ахуй нэгжийн тоо 48.2%-иар тус тус өссөн байна. /Хавсралт-2, График 6/

9. Хяналтын ажлын үр дүн, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж олон нийтэд хүргэсэн мэдээ мэдээллийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар, олон нийтэд өгсөн ном гарын авлалга, сэрэмжлүүлэг 2 дахин тус тус өссөн байна. /Хавсралт-2, График 12/

10. Иргэн, олон нийтэд хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдэл өмнөх оныхтой харьцуулахад 3 дахин өссөн нь иргэдийг болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ болсон. /Хавсралт-2, График 14/

11. Зохион байгуулалтын нэгж, хэлтсүүдийн үйл ажиллагаа, улсын байцаагчдын үйлдсэн баримт бичигт дотоод хяналт шалгалт хийж, гарсан алдааг засуулан, дүгнэлт, зөвлөмж гаргаж ажилласан нь ажлын чанар үр дүн сайжрах нөхцөлийг бүрдүүлсэн.

12. Шилэн хяналтын цахим систем, хэлтэс, нэгжүүдээс ирүүлсэн үйл ажиллагааны мэдээлэлд үндэслэн ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийн үнэлэлт өгч, улсын байцаагчдын ажлыг сар, улирал, хагас жилээр дүгнэн хариуцлага тооцон ажилласан нь ажлын гүйцэтгэл сайжрахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

13. 2019 онд томоохон төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх шалгалтуудыг төрийн байгууллагуудтай хамтран хийж, ажлын уялдаа холбоог сайжруулан, хяналт шалгалтын давхардлыг арилгахад анхаарсан байна.

14. Төрийн албаны тухай шинэчлэн батлагдсан хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын мэдээллийг шинэчилж, бүртгэлжүүлэх, хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт үзлэг хийж, ажилласан жилийн судалгааг баталгаажуулах, зэрэг, дэв, ур чадварыг шинэчлэн тогтоох зэрэг хүний нөөцийн чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

15. 2014-2018 оны эрсдэлийн үнэлгээ, 2018 оны төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн, бусад хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний гүйцэтгэл, авсан арга

хэмжээ, лабораторийн үйл ажиллагаа, эрсдэлээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажиллагааны үр дүн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн нь эрсдэлийн төлөв байдлыг бодитой тодорхойлох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үр дүнг сайжруулахад тоон мэдээллийг ашиглах, улмаар улсын байцаагчид өөрийн хариуцсан чиглэлээр дүн шинжилгээ хийж хэвшихэд ач холбогдолтой эмхэтгэл болсон.

ДӨРӨВ: ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

2019 оны үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Бодлогын түвшинд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай хяналт шалгалтын явцад тулгамдаж байгаа асуудлын талаар

- Хууль сахин биелүүлж даган мөрддөг бизнесийг нийгэмд сурталчлах, нөлөөллийг нэмэгдүүлэх, туршлагыг дэлгэрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, хууль сахин биелүүлэлтийн хандлагыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан хэрэгжүүлэх, хяналтын чиглэл бүрээр хууль сахин биелүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээл, шалтгаан, хууль сахин биелүүлэх зан үйл, хандлагад судалгаа хийх;
- Төрийн албаны хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар, тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалд нийцүүлэн Мэргэжлийн хяналтын байгууллагын тайлан гаргах, илгээх, хүлээн авах журам, зааврыг шинэчлэх;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан боловсруулах, тайлагнах чиглэлээр Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагаас сургалт, арга зүйн зөвлөгөө авах;
- 2020 оны төлөвлөлтийг байгууллагын стратеги төлөвлөгөө болон бодлогын баримт бичиг бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдуулан хийх;
- Шилэн хяналтын цахим системийг хялбаршуулах, боловсронгуй болгох;
- Хүнсний аюулгүй байдал fsi.gov.mn бүртгэл мэдээллийн санд орсон мэдээллийг ашиглахад хялбар болгож, программыг шинэчлэх;
- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх цахим системийг боловсронгуй болгож, Шилэн хяналтын систем, эрсдэлийн үнэлгээтэй уялдуулах;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд зааснаар мэдээллийн санд бүртгүүлж буй аж ахуйн нэгж, иргэний бүртгэлийн системийн үйл ажиллагаа үр дүнг ашиглах боломжтой болгож, хүнсний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сантай холбох;
- Шадар сайдын баталсан 2011 оны 71 дүгээртушаалаар батлагдсан “Байгаль орчин, Хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын дүрэмт хувцас хэрэглэх, хангах журам”-ын дагуу гүний хяналтад ажиллаж байгаа улсын байцаагчдыг ажлын дүрэмт хувцсаар хангах асуудлыг шийдвэрлэх;

- Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай багаж, техник хэрэгсэл /хэмжилтийн багажууд, зөөврийн компьютер, зургийн аппарат, диктафон, бусад/-ийн хангамж хүрэлцээг сайжруулах;
- Шинжилгээнд хамруулсан импортын бодис, бараа бүтээгдэхүүний хариуг гартал битүүмжлэн хадгалах стандартын шаардлага хангасан агуулахтай болох;
- Улсын төсөвт оруулж байгаа Лабораторийн орлогоос тодорхой хувийг лабораторид шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, шинжилгээний шил сав урвалж бодис, тэжээлт орчин худалдаж авахад хуваарилдаг болгох саналыг шийдвэрлүүлэх;
- Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод ажилладаг улсын байцаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулах, баяр наадам, бүх нийтийн амралтын өдрүүдэд ээлжинд үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд цалингийн нэмэгдлийг олгох ;
- Лабораторийн шинжилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан, техник, тоног төхөөрөмж багаж хэрэгслийн шинэчлэл хийх, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин үеийн техник хэрэгслээр хангах, одоо ашиглаж байгаа хурдавчилсан болон физик хэмжилтийн багаж, хэрэгсэлд туршилт, баталгаажуулалт хийлгэх;
- Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдийн рентген аппаратуудын цацрагийн аюулгүй ажиллагаанд тавих цацрагийн хяналтыг иж бүрэн хийхэд шаардлагатай чанарын хяналтын багажаар хангах;
- Импортын бодис, бараа бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан тохиолдолд шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд түр битүүмжлэн хадгалах стандартын шаардлага хангасан агуулахтай болох асуудлыг шийдвэрлэх;

2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

- Зөрчлийн тухай хуульд өгсөн саналын дагуу нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг эрчимжүүлэх;
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг дагаж гарах дүрэм, журмуудыг батлуулж мөрдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагын стандартуудыг шинэчлэх, хүнсний жижиг дунд үйлдвэрүүдэд тавигдах шаардлагын стандартыг боловсруулах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946:2005 стандартыг шинэчлэх саналыг ХХААХҮЯ, Стандартчилал, хэмжил зүйн газарт уламжлах;
- Худалдааны газрын шаардлагын стандартыг нэр томъёоны стандарттай уялдуулж, яаралтай шинэчлэн гаргах саналыг уламжлах;

3. Ажиллагсдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар:

- Мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид, улсын байцаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр судалгаа хийж, төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээсийн орон сууцны

хөтөлбөрт хамруулах, орон байрны нөхцөлөө сайжруулах, зуслангийн газартай болоход нь үе шаттай дэмжлэг үзүүлэх;


- Мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагаар мэргэшсэн мэдлэг, чадвар бүхий улсын байцаагчдыг нэмэгдүүлэхэд үе шаттай арга хэмжээ авах;
- Улсын байцаагчдыг гадаадын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын үйл ажиллагаа, техник технологийн хөгжилтэй танилцуулах, туршлага судлуулах ажлыг өргөжүүлэх;
- Ажлын нөхцөл нь хэвийн бус нөхцөлд хамаарагдах улсын байцаагчдад нэмэгдэл олгох, болон эмчийн үзлэгт жил бүр хамруулахад дэмжлэг үзүүлэх асуудлыг судлах;
- Улсын байцаагчдын ажлын нөхцөлийн судалгаа гаргаж, цөмийн болон цацрагийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуй хяналтын чиглэлээр ажиллаж байгаа улсын байцаагчдын ажлыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд оруулах саналыг судлах;
- Улсын байцаагчдад зориулсан сургалтын модуль боловсруулах, кредит хангуулах сургалтад үе шаттайгаар хамруулах;

ХАВСРАЛТ 1

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

1. Төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэл

/График -1/




2019 онд НМХГ-ын хэмжээнд **4700** төлөвлөгөөт шалгалт, **2754** төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар **4659 (99.1%)** төлөвлөгөөт шалгалт, **2590 (94.0%)** төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

Үүнээс үйл ажиллагаа зогссон, хяналт шалгалт хийх боломжгүй 422 төлөвлөгөөт шалгалт буюу төлөвлөлтийн 8.9%, 137 зөвлөн туслах үйлчилгээ буюу төлөвлөлтийн 4.9% байна.

2. 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар батлагдсан бусад хяналтын хэрэгжилт


/График -2/



НМХГ-аас 2019 онд 7982 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 325 объектод хяналт шинжилгээ, 676 объектод тандалт судлагаа, 1277 объектод салбарын сургалт, 408 объектод баталгаажуулалт хийсэн байна.

3. Объектын эрсдэлийн үнэлгээ

/График - 3/




2019 онд нийт **44851** объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн нь өмнөх оноос 747 объект буюу **1.7 хувиар өссөн** үзүүлэлттэй байна.

2019 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ӨНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

1. Улсын байцаагчийн үйлдсэн баримт бичгийн үзүүлэлт

/График -4/




Улсын /ахлах/ байцаагчдын үйлдсэн акт, албан шаардлага, дүгнэлтийг авч үзвэл үйлдсэн дүгнэлт 19.8 хувиар, акт 3.9 хувиар, албан шаардлагын тоо 30.0 хувиар тус тус өссөн байна.

Мөн актын биелэлт 2019 онд 95.5 хувьтай, албан шаардлагын биелэлт 94.7 хувьтай биелэгдсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад актын биелэлт 3.5 хувиар буурсан бол албан шаардлагын биелэлт 1.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

/График -5/


Улсын /ахлах/ байцаагчдын үйлдсэн дүгнэлт



Улсын байцаагчийн үйлдсэн үйл ажиллагааны дүгнэлт өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар, бүтээгдэхүүний дүгнэлт 23.5 хувиар тус тус өссөн бол ажлын байрны дүгнэлт 54.4 хувиар буурсан байна.

2. Үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн үзүүлэлт

/График - 6/



2019 онд зөрчил гаргасан 183 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, зөрчлөө арилгасан 86 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сэргээсэн нь өмнөх оноос үйл ажиллагааг түр зогсоосон аж ахуйн нэгжийн тоо 39.7 хувиар, үйл ажиллагааг сэргээсэн аж ахуй нэгжийн тоо 48.2 хувиар тус тус өссөн байна.

3. Нөхөн төлбөр, торгууль, шийтгэвэр түүний барагдуулалт /мян.төг/


/Хүснэгт-1/

Үзүүлэлтүүд	2018	2019	Хувь
Тогтоосон торгууль	2 401 773.0	3 335 694.1	38.9%-иар өссөн
Барагдуулсан	2 108 673.0	3 002 649.1	42.4%-иар өссөн
Хугацаа болоогүй	304 630.0	327 045.0	7.3%-иар өссөн
Нийт барагдуулалтын хувь	87.8%	90.0%	2.2%-иар өссөн
Тогтоосон нөхөн төлбөр	1 467 242.8	1 499 739.9	2.2%-иар өссөн
Барагдуулсан нөхөн төлбөр	571 599.0	1 139 623.3	99.4%-иар өссөн
Хугацаа болоогүй	370 984.0	360 115.6	2.9%-иар буурсан
Хүчингүй болсон	0	0	-
Нийт барагдуулалтын хувь	39.0%	76.0%	37%-иар өссөн

/График - 7/

Торгууль, шийтгэвэр /мян.төг/


2019 онд нийт 3335694.1 мянган төгрөгийн торгууль, шийтгэвэр тогтоосон нь өмнөх оны мөн үеэс 933921.1 мянган төгрөг буюу 38.9 хувиар, барагдуулсан торгууль шийтгэвэр 893976.1 мянган төгрөгөөр буюу 42.4 хувир тус тус өссөн байна. Торгуулийн нийт барагдуулалтын хувь 90.0 хувь байгаа нь өмнө оноос 2.2 хувиар өссөн байна.



/График -8/

Нөхөн төлбөр /мян.төг/

Хяналт шалгалтаар нийт 1499739.9 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 1139623.3 мянган төгрөг буюу 76.0 хувийг барагдуулсан нь өмнөх оны мөн үеэс тогтоосон нөхөн төлбөр 2.2 хувиар, барагдуулсан нөхөн төлбөр 99.4 хувиар тус тус өссөн байна. Нийт барагдуулалтын хувь өмнөх оноос 37.0 хувиар өссөн.



4. Улсын орлого болгосон, хурааж устгасан эд зүйлс /мян.төг/

Улсын орлого болгосон эд зүйлийн дүн 22586.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 221627.3 мянган төгрөг буюу 10.8 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Харин 1805245.9 мянган төгрөгийн эд зүйлсийн хурааж устгасан нь өмнөх оноос 789669.9 мянган төгрөгөөр буюу 1.7 дахин өссөн байна.




/График -9/

5. Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн үзүүлэлт

2018 онд 31606 зөрчил илрүүлж, 27368 зөрчил буюу 86.6 хувийг, 2019 оны байдлаар 46679 зөрчил илрүүлж, 35103 зөрчил буюу 75.2 хувийг богино хугацаанд арилгуулан ажилласан байна. Зөрчил арилгуулалтын хувь өмнөх оноос 11.4%-иар буурсан дүнтэй байна.


/График -10/



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад илрүүлсэн зөрчил 15073 (47.7%)-иар, арилгуулсан зөрчил мөн 7735 (28.3%) хувиар тус тус өссөн байна.

6. Албан бичиг, өргөдөл, гомдол


/График -11/



Тайлант хугацаанд нийт 16034 албан бичиг, 7302 өргөдөл гомдол хүлээн авсан нь өмнөх онтой харьцуулахад албан бичиг 9.2%, өргөдөл гомдол 43.5%-иар тус тус өссөн дүнтэй байна.

7. Хэвлэл мэдээллийн сурталчилгаа /хяналтын чиглэл давхардсан тоогоор/


/График -12/



Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан мэдээ мэдээллийн тоо өмнөх оноос 300 буюу 3.9 хувиар, олон нийтэд өгсөн ном, гарын авлага, сэрэмжлүүлэг 2.0 дахин тус тус өссөн байна.

8. Сургалт


/График -13/



Аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд зохион байгуулсан сургалтын тоо өмнөх оны мөн үеэс 192 сургалт буюу 27.2%-иар буурсан бол улсын байцаагчдад зориулсан дотоод сургалтын тоо 37 сургалт буюу 7.6 хувиар өссөн байна.

9. Зөвлөмж, мэдэгдэл

/График -14/



НМХГ-аас 2019 онд боловсруулсан зөвлөмж, мэдэгдлийн тоо өмнөх оны мөн үеэс 1.8 дахин, хүргүүлсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн тоо 3.0 дахин тус тус өссөн дүнтэй байна.

-000-

ХАВСРАЛТ 3

НМХГ-ААС 2019 ОНД ХИЙСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

НЭГ: НАЛАЙХ ДҮҮРЭГТ НҮҮРС ОЛБОРЛОГЧ АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ МӨРДҮҮЛЭХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Налайх дүүрэг дэх нүүрс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч 22 аж ахуйн нэгжийн 72 ам цооногийн 725 иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 17 иргэний зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн 2.700.0 мян төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 72 ам цооногийн үйл ажиллагааг зогсоох саналыг НЗДТГ-т хүргүүлж, ашигт малтмал ашиглах гэрээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага хангаагүй, далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлага хангаагүй 32 ам, цооногийн үйл ажиллагааг зогсоолоо.

Үр дүн : Хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, хүний амь нас, эрүүл мэнд эрсдэх аюулаас урьдчилан сэргийлсэн.

Ашигт малтмал ашиглах гэрээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага хангаагүй, далд уурхай



ХОЁР: АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ МӨРДҮҮЛЭХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн нутаг дэвсгэрт 266 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлээгүй, нөхөн сэргээлт хийгээгүй 48 аж ахуйн нэгжид олборлолтын үйл ажиллагаа эхлүүлэхгүй байх тухай мэдэгдлийг хүргүүлж, биелэлтийг хангууллаа. Холбогдох хууль тогтоомж зөрчсөн аж ахуйн нэгж, иргэдэд 36,600,0 сая.төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 34 аж ахуйн нэгжийн хайгуулын тусгай

зөвшөөрлийг сунгахгүй байх тухай, нөхөн сэргээлт хийгээгүй 14 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналуудыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлээ.

Үр дүн: Байгаль орчныг бохирдох, хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирлоос урьдчилан сэргийлсэн.

*Байгаль орчны хамгаалах үүргээ биелүүлээгүй,
нөхөн сэргээлт хийгээгүй байдал*



ГУРАВ: СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ БОЛОН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙД АШИГЛАЖ БАЙГАА ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ УТАС, КАБЕЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

3.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд ашиглаж байгаа цахилгаан дамжуулах утас, кабелийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийж 19 ААНБ, иргэний ил задгай, кабель шугамыг засварлаж, газарт булуулж, ашиглагдахгүй байгаа 7 гэрэлтүүлгийн шон, цахилгаан дамжуулах тулгуурыг буулгуулж, шаардлага хангахгүй 154 метр цахилгаан дамжуулах кабель шугамыг хураан авч, сургууль цэцэрлэгийн ойр орчимд байрлах 6 агаарын тулгуурыг тэгшитгэж, 7 дэд станцын хаалгыг засварлан цоожтой болгож, өндөр хүчдэлийн шугамын доор байрласан 8 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний үйл ажиллагааг зогсоож, хамгаалалтын зурвасыг чөлөөлсөн. Хан-Уул дүүргийн 6 дугаар хороонд байрлах “Петростар” ХХК-ийн ШТС-ийн дэд станцийн тэжээлийн цахилгаан дамжуулах кабель шугам илээр татагдаж аюулгүй ажиллагаа алдагдсан, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороонд байрлах хаалттай станцын трансформаторын орох гарцыг хаасан зөрчлүүдийг арилгууллаа.

3.2 Сургууль, цэцэрлэг, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд ашиглаж байгаа цахилгаан дамжуулах утас, кабел, орон сууц, гэр хорооллын хэрэглэгчдийн цахилгаан тоног, төхөөрөмж, шугам сүлжээ, тоолуурын самбар, хайрцаг, холболтын аюулгүй байдлыг хангуулах, сургууль цэцэрлэг, эмнэлгийн орчны аюулгүй байдлыг хангуулах, иргэдийг болзошгүй осол, аваар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл, зөвлөмжийг “УБЦТС”, БСШУСЯ, ЭМЯ-нд тус тус хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллалаа.

Үр дүн : Цахилгаан эрчим хүчний аюулгүй ажиллагааг хангуулж, хүн, амьтан, осолдохоос урьдчилан сэргийлж, эрчим хүчний тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулсан.

СХД, 38 Айлын Б 96 тулгуур хугарч унасанг бетон тулгуураар сольж, 4 пролет шугам залгаа хийж чангалав.



ДӨРӨВ: БАРИЛГА УГСРАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

4.1 Нийслэлд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд баригдаж буй 69 барилгын 69 ерөнхий гүйцэтгэгч, 30 туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Барилгын үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад нийтийн эзэмшлийн зам талбай болон барилгын үйлдвэрлэлийн орчинд тэмдэг тэмдэглэгээ бүхий хаалт хамгаалалт тусгаарлалт, эрэг нуралтаас хамгаалах бэхэлгээ, хийгээгүй, ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлгүй, аюултай бүсийн хил хязгаарыг тогтоогоогүй, хүн унаж болзошгүй нүхийг хаалт хамгаалалтаар тусгаарлаагүй, тэмдэг тэмдэглэгээ тавиагүй, стандарт бус орц гарцтай, барилгын талбай эмх цэгцгүй зэрэг илэрсэн зөрчлийг арилгуулахаар 30 аж ахуйн нэгж байгууллагад 36350.0 мянган төгрөгийн торгууль, 2880.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 18 аж ахуйн нэгж байгууллагад 112 заалт бүхий зөрчил арилгах хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Хяналт шалгалтын үр дүнд 17 аж ахуйн нэгж байгууллагад нийтийн эзэмшлийн зам талбай, захын хийцүүд болон барилгын үйлдвэрлэлийн орчинд тэмдэг тэмдэглэгээ бүхий хаалт хамгаалалт, 7 аж ахуйн нэгж, байгууллагад эрэг нуралтаас сэргийлэх бэхэлгээ, хаалт хамгаалалт хийлгэж, 22 аж ахуйн нэгжийн 131 ажилчдад ажлын хувцас, хувийн

хамгаалах хэрэгсэл олгуулж, 23 барилгын объектод хүн унаж болзошгүй нүхэнд хаалт хамгаалалт, тэмдэг тэмдэглэгээ хийлгэж, 12 стандарт бус орц гарцыг шинэчлэн засварлуулж, 6 барилгын объектын хашааг стандартын шаардлагад нийцүүлэн засууллаа.

4.2 “Жунсон констракшн” ХХК-ийн барилга угсралтын талбайд барилга угсралтын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрүүл аюулгүй ажлын байр” сэдэвт үзүүлэх сургуулийг нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 120 аж ахуйн нэгж байгууллагуудын дунд зохион байгууллаа.

Үр дүн: Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангуулж, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах эрсдэлээс урьдчилан сэргийлсэн.



Захын хаалт хамгаалалт хийгээгүй байдал



Захын хаалт хамгаалалт хийсэн байдал



Эргийн хаалт хамгаалалт хийгээгүй байдал



Хаалт хамгаалалт хийсэн байдал

“Жунсон констракшн” ХХК-ийн барилгын талбайд хийсэн үзүүлэх сургууль



ТАВ: ГАЗРЫН ЗӨРЧИЛ АРИЛГАХ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ ТАЛБАЙ, ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТАЛБАЙГ ЧӨЛӨӨЛҮҮЛЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ МӨРДҮҮЛЭХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

5.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт ил задгай авто машины худалдаа эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагад Нийслэлийн газар зохион байгуулалтын албатай хамтран төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 62 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсанаас газраа зориулалтын дагуу ашиглах хугацаатай мэдэгдлийг өгч, зөрчлөө арилгаагүй 15 аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийг хүчингүй болгох, өмчлөх эрхийн гэрчилгээтэй 31 иргэнийг газрыг хураан авах шийдвэр гаргуулахаар саналыг НЗД-д хүргүүлсэн.

Зориулалтын бус байдалд автомашины худалдаа эрхэлж байгаа байдал



Авто машины нүүлгэн шилжүүлэлт хийсэн байдал



5.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын зөрчил арилгах, нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам, талбайг чөлөөлүүлэх удирдамжийн хүрээнд 12 иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй газар ашиглаж өргөтгөл барьсан 5 иргэн, аж ахуйн нэгжийн зөрчлийг арилгуулж, 12 иргэнд 13730,0 мян төгрөгийн торгууль ногдуулж, холбогдох арга хэмжээг авсан байна.

5.3 Газрын харилцааны чиглэлээр газрын зөрчил маргаанд зөвлөмж, зөвлөгөө өгөх “Нээлттэй хаалга”-ны өдрийг Барилгачдын талбайд зохион байгуулж, геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөл эзэмшигч мэргэжлийн байгууллага, газрын хянан баталгаа хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага оролцуулан, нийт 16 чиглэлээр 1500 гаруй тараах материал, гарын авлага, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 13 төрлийн 450 орчим зөвлөмж, сэрэмжлүүлэг, 1200 танилцуулга, 300 плакат тараалаа.

Үр дүн : Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлсэн.

Нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам, талбайг чөлөөлүүлж буй байдал





ЗУРГАА: ТҮҮХИЙ НҮҮРС ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН 62 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн шуурхай штабт, агаарын чанарыг сайжруулах бүсэд харьяалагдах 154 хороонд, Эмээлт, Морин Өлзийт-1, 2, Гүнт, Баруунтуруун, Гачуурт, Хонхор зэрэг авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод болон маршрутын бус цэгүүдэд, “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн ажиллагаа, хангамжийн 10 бааз, дундын 17 агуулах, борлуулалтын 390 цэгүүдэд нийт 453 улсын байцаагч, албан хаагчид хяналт тавин ажилласан.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 560.0 сая төгрөгийн санхүүжилтээр авто тээврийн шалган нэвтрүүлэх иж бүрэн, явуулын 4 хяналтын цэг, түүнд ажиллах 24 эргүүл, хяналтын ажилтны төсвийг шийдвэрлэж, 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Nissan leaf маркын бүрэн цахилгаан авто машин худалдан авч Улаанбаатар хот руу зөвшөөрөлгүйгээр түүхий нүүрс болон хууль бус тээвэрлэлтийн үйл ажиллагаанд 24 цагаар тасралтгүй хяналт тавьж ажиллаж байна.

Дээрх ажлын хүрээнд

1. ЭМЯ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НЭМҮТ, НЗДТГ-тай хамтран “Түүхий нүүрсний хор уршгийг иргэдэд таниулах өдөрлөг”-ийг Сүхбаатарын талбайд зохион байгуулж иргэдэд агаарын бохирдлын эх үүсвэр, сөрөг үр дагаврын талаар мэдээлэл сурталчилгаа хийлээ.

2. Агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч 5388 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, 2210 мэдэгдэл, зөвлөмж, албан шаардлага хүргүүлж, илэрсэн зөрчилд үндэслэн нийт **179 сая 150.0** мянган төгрөгийн торгууль ногдууллаа.

Үүнээс нүүрс тээвэрлэх зөвшөөрөлгүйгээр Улаанбаатар хот руу нэвтрэхийг завдсан 236.58 тн түүхий нүүрсийг улсын байцаагчийн 29 актаар хураан Амгалан дулааны станцид хүлээлгэн өгч, 2200.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа.

3. 1080 объектод цахилгаан халаагуур тавиулж, 1561 объект зуухыг сайжруулсан зуухаар солиулж, жилд түлэх түүхий нүүрсний хэмжээг **6000-6200** тн-оор бууруулж, агаарт **650-700** тн, **72.1-74.5**тн хүхрийн давхар исэл, **27.9-28.83**тн азотын ислүүд, **46.1-47.67**тн PM10 тоосонцор, **274.1-283.2**тн угаарын хий хаягдахаас урьдчилан сэргийллээ.

4. Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэгч Улаанбаатар цэвэр агаар төсөл, лаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл, Япон улсын Комотек

корпораци, Олимпиус когия компани, JCM /Хамтарсан кредит олгох механизм/, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Агаарын бохирдолтой тэмцэх газартай хамтран ажиллаж, 15 сая төгрөгийн санхүүжилтээр Тесто багажийг ашиглалтад оруулж, халаалтын зуухны хаягдал утааны хэмжилт бие даан хийх нөхцөлөөр хангах, 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр агаарын хяналтын улсын байцаагчдын шатахууны зардал, 15 сая төгрөгийн санхүүжилтээр агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр гарын авлага тараах материал, “Агаар бохирдуулагч суурин эх үүсвэр ашиглагчдын байршлын зураглал /атлас/ хийх” асуудлыг шийдвэрлэлээ.

5. Нийслэлийн Засаг даргын санхүүжилтээр авсан дроноор Таван толгойн түлш ХХК-ийн шахмал түлшний 1 дүгээр үйлдвэрийн зураглал, Баянзүрх, Согинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар 8 байршлаас агаарын бохирдлын зураглал хийж 2018 оны өвлийн улиралтай харьцуулан байгууллагын вэб сайтад байршуулан олон нийтэд мэдээлсэн.

6. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Чингэлтэй дүүргийн төр захиргааны байгууллагын удирдлагууд, албан хаагчид, улсын байцаагчид, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга, Орон тооны бус ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг цаг алдалгүй арилгах, айл өрх, иргэд, ААНБ-д холбогдох тогтоол шийдвэрийг сурталчлах, хяналт тавих улмаар Иргэдийн эрүүл, аюулгүй, утаагүй, цэвэр орчинд аж төрөх нөхцөлийг бүрдүүлэхэд бүх шатандаа нэг баг болж ажиллах талаар “ЧИНГЭЛТЭЙЧҮҮД – АГААРЫН БОХИРДЛЫН ЭСРЭГ ХҮЧЭЭ НЭГТГЭЖ БАЙНА” зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Үр дүн: Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Засгийн газрын 2019 оны 62 дугаар тогтоол хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд 2019 оны 11 дүгээр сарын дундаж өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад нарийн ширхэглэгт PM2.5 тоосонцор 43%-иар, том ширхэгт PM10 тоосонцор 42%-иар тус тус багасч, Улаанбаатар хотын агаарын бохирдол утааны хэмжээ мэдэгдэхүйц буурсан байна.

Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоон дахь түүхий нүүрсний хяналт



“Таван толгой түлш” ХХК-ийн шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа нь



ХХК халаалтын зуухаа буулгаж байгаа байдал



“Эко

констракшн”



“Чингэлтэйчүүд – агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэж байна” зөвлөгөөн



ДОЛОО.НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ БАРИГДАЖ БАЙГАА БАРИЛГУУДАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ МӨРДҮҮЛЭХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн хотын нутаг дэвсгэрт шинээр баригдаж байгаа барилгуудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хийсэн шалгалтад нийт 374 ААН, иргэний 569 блок барилгыг хамруулснаас барилгын угсралтын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ, архитектур төлөвлөлтийн даалгавар аваагүй 41-н барилгад зөрчлийг арилгах тухай 30 албан даалгавар өгч, 112,5 сая төгрөгийн торгууль ногдуулж, 167 зөвлөмж, 168 мэдэгдэл, дүгнэлт, улсын байцаагчийн албан шаардлага, акт гаргаж, холбогдох байгууллага, ААН, иргэнд хүргүүлсэн.

Үр дүн : 9 барилга зөрчлөө арилган угсралтын ажилд зохих байгууллагаас зөвшөөрлийг олгож, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангуулж, хөдөлмөр эрхлэгч иргэнийг аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.

Зөвшөөрөлгүй баригдаж байгаа барилгууд



СБД 7 хороо иргэн Б-ийн барилга



СХД 27 хороо ИЗИС ажилчдын орон сууц



БЗД 25 хороо иргэн М-ын орон сууц

НАЙМ: ЭКСПОРТ, ИМПОРТ, ХИЛИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Гүний гаалийн хяналтын бүсээр “Некст женерэйшн хеалт” ХХК-ийн “Аменорм” нэрийн 62.7 кг, 12960000 төгрөгийн үнэ бүхий биологийн идэвхт бүтээгдэхүүн, БНСУ-аас тусгай зөвшөөрөлгүйгээр 39 ширхэг, 1.020.000 төгрөгийн тарилгын уусмал, нүдний линз импортолсныг хурааж, нийт 50439 ш, 13.980.000 төгрөгийн бүтээгдэхүүнийг холбогдох байгууллагад шилжүүлсэн.

“Алтан торх русс” ХХК-ийн импортолсон 2 нэрийн хөлдсөн 3440 хайрцаг, 64.697.000 төгрөгийн шар айраг, “Энто” ХХК-ийн БНСУ-аас импортолсон “Уранитин” нэрийн 3.7 тн, 140.056.200 төгрөгний хөлдсөн уусмал эм, “Вольтам” ХХК-ийн Казахстан улсаас импортолсон хугацаа дууссан, “Mevius option revo blue, Mevius option white” нэрийн 540 хайрцаг, 810 сая төгрөгний янжуур тамхи, нийт 4 нэрийн 1 тэрбум 14 сая 800 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг журмын дагуу гаалийн горимоор тус тус устгасан.

Үр дүн: Бараа бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангуулж, иргэдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн.

Шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүнийг устгасан нь



ЕС: ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

9.1 Сүхбаатар дүүрэгт байрлах “Зүшунфа” ХХК-ийн Бээжин хүнсний дэлгүүрийн Хангай зочид буудлын 1 давхарт байрлах зориулалтын бус агуулахад хадгалж, худалдаалж байсан хаяг шошгын зөрчилтэй, гарал үүсэл тодорхойгүй, зөвшөөрөгдөх эрсдэлийг тогтоолгоогүй, шинжилгээ баталгаажуултгүй, импортын мэдэгдэлгүй 160.6 сая

төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч холбогдох байгууллагад шилжүүлэн, 10.0 сая төгрөгийн торгуулийн шийтгэл ногдууллаа.

9.2 Баянгол дүүргийн “Эм Жей Партнерс” ХХК-ийн Япон Улсаас импортолсон 1 сортын хальсалсан цагаан будаанаас гадаад хорио цээртэй шөвгөр хошуут цох илэрсэн тул 5.0 сая төгрөгөөр торгон, 1632 кг хальсалсан цагаан будааг хураан авч, холбогдох байгууллагад шилжүүлсэн.

Эрүүл ахуйн шаардлага хангаагүй цагаан будаа



9.3 Хан-Уул дүүргийн нийтийн орон сууцны байрны нэг давхарт байрлаж, зохих зөвшөөрөлгүй, стандарт, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангаагүй, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд бусаар хордохирол учруулж болох нөхцөл байдал үүссэн зөрчлийг илрүүлэн нийтийн эрх ашгийг зөрчсөн 8 газрын үйл ажиллагааг зогсоож, 2 газрын тусгай зөвшөөрлийг цуцлууллаа.

Нийтийн орон сууцны байрны нэг давхрын хоолны газар



Үр дүн: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулж, иргэдийг болзошгүй хордлого халдвараас урьдчилан сэргийлсэн.

Зориулалтын бус агуулахад хадгалж, худалдаалж байсан бараа бүтээгдэхүүн



АРАВ: АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД АВСАН АРГА ХЭМЖЭЭ

10.1 НМХГ-ын чиглэлийн хэлтсийн болон Баянзүрх дүүрэг МХХ-ийн нийт 217, улсын /ахлах/ байцаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, томуугийн дархлаажуулалтад хамруулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа.

10.2 БОАЖЯ-ны санхүүжилтээр 148,989.0 мян. төгрөгийн авто тээврийн товчооны 4ш явуулын ажлын байр, 21,500.0 мян.төгрөгийн бүрэн цахилгаан автомашин нэг, 15,590.0 мян.төгрөгийн Нисдэг камерын багц, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээр Багануур дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст 19,700.0 мян.төгрөгийн “Тоёота Приус-30” маркийн суудлын автомашин нэг, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу 400,000.0 мян.төгрөгийн 8ш “Тоёота Приус-30” маркийн суудлын автомашин, 85 ш компьютер, принтер, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжөөр материаллаг баазыг бэхжүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжрууллаа.

Үр дүн: Албан хаагчдыг халдварт бус өвчний эрсдэлд хүчин зүйлд өртөх, өвчлөх, хожуу оношлогдон хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлж, байгууллагын материаллаг бааз бэхжиж, үйл ажиллагааны шуурхай байдал хангагдсан.

Албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж байгаа нь



Байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх талаар авсан арга хэмжээ



АРВАН НЭГ: НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

11.1 Хөдөлмөр нийгмийн хамгаалал тусгай хяналтын хэлтэс, Монконкстракшн ХХК-ийн санаачилгаар “Сайн үйлсийн төлөө ХАБ-ууд нэгдэцгээе” аяны хүрээнд 70 гаруй компанийн 203 ажилтан Нархан, Эрдэм, Бадамлянхуа, Манна, Сарнай зэрэг 5 хүүхдийн асрамжийн газарт нийт 58 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, тохижуулалтын ажлыг хийсэн.

11.2 Хан-уул дүүргийн 7 дугаар хорооны зорилтод бүлгийн 30 өрх айлын хүүхдүүдэд сургалт соён гэгээрүүлэх чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллалаа.

Үр дүн: Төр хувийн хэвшлийн нийгмийн хариуцлага, хамтын ажиллагаа дээшилж, нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлсэн.

АРВАН ХОЁР: ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

12.1 “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд НМХГ-ын байр, 6 дүүрэг дэх МХХ, Төв лаборатори, гаалийн бүс дэх 13 ажлын байр нийт 21 ажлын байранд саналын хайрцгийг нээж, иргэдээс ирсэн саналыг нэгтгэн, үйл ажиллагаандаа тусгалаа.

12.2 Хан-Уул дүүргийн 1-16 хорооны иргэдэд Байгаль орчин, Мал эмнэлэг, Хүнсний чанар, стандарт, Агаарын тухай хууль, орчны бохирдлын чиглэлээр өдөрлөг зохион байгуулан ажиллалаа. Тус дүүргийн бүх хороодод хороодын удирдлага, албан хаагчид, ард, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн санал гомдлыг хэрхэн шийдвэрлэж ажилласан талаар танилцуулга хийж, тулгамдаж буй асуудлаар зөвлөн тусалж ажиллалаа.

12.3 Чингэлтэй дүүрэг МХХ нь “Иргэн төвтэй-Төрийн үйлчилгээ” аяны хүрээнд нэг хороонд 10 хоног нийт 19 хороодод төрийн бүх байгууллагуудтай хамтран төрийн

үйлчилгээг иргэдэд газар дээр нь үзүүлж, 36 санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажиллалаа.

Үр дүн: Төрийн үйлчилгээг газар дээрээс нь шуурхай үзүүлж, шийдвэрлэсэн.

Иргэдээс авсан саналын хайрцгийг нээж байгаа нь



Иргэдтэй хийсэн уулзалт



АРВАН ГУРАВ: АЛБАН ХААГЧДЫГ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

1. НМХГ-ын Тамгын газраас удирдах ажилтан, улсын байцаагчдын албан хэрэгцээнд зориулж, “НМХГ-аас 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний эмхэтгэл”, “2019 онд хийх хяналт шалгалтын календарьчилсан төлөвлөгөө”, “Мэдээ тайлан, төлөвлөгөөний биелэлт хүргүүлэх хуваарь”, “2019 оны сургалтын календарьчилсан төлөвлөгөө”, 2019 оны үйл ажиллагааны мэдээллийг багтаасан ширээний календарь, НМХГын “Хяналт шалгалтын объект”, “2014-2018 оны Эрсдэлийн үнэлгээ”, 2018 оны хяналт шалгалтын төлөвлөлт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт, осол хордлогын дуудлагаар хийсэн хяналт шалгалт, үр дүнд хийсэн дүн шинжилгээнүүд, “Уул уурхайн дүрэм журам, стандартын эмхэтгэл цуврал 1” зэрэг материалыг хэвлүүлэн улсын байцаагч, удирдах ажилтнуудын албан хэрэгцээнд хүргүүлж, цаашид анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулсан.

Үр дүн: Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны чанарыг сайжруулж, үр дүнтэй, ил тод, шуурхай байдлыг хангахад дэмжлэг үзүүлсэн.

Эрсдэлийн төлөвлөлт, дүн шинжилгээний ном, гарын авлагууд

